



The Asia Foundation

IRIM **ONGOLIA**
Independent Research Institute

Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх төсөл

Төгсгөлийн үнэлгээний тайлан

Улаанбаатар хот.
2015 он.

АГУУЛГА

Дүрсийн жагсаалт.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	3
Хураангуй	1
Бүлэг I. Танилцуулга	5
Бүлэг II. Арга зүй	7
Бүлэг IV. Иргэдийн судалгааны үр дүн	13
1. Ойлголт мэдлэгийн түвшинд гарсан өөрчлөлтүүд	13
2. Иргэдийн оролцооны түвшинд гарсан өөрчлөлтүүд	24
3. Хөндлөн суралцах	36
4. Иргэдийн санал хүсэлт болон гомдол	39
Бүлэг V. орон нутгийн захиргааны албан хаагчдын судалгааны үр дүн	45
1. Хамаарал.....	45
2. Ашигт ажиллагаа	47
3. Бүтээмж.....	48
4. Тогтвортой хөгжил.....	50
Бүлэг VI. Дүгнэлт	50
Хавсралт I. Судалгааны хэрэглэгдэхүүн	53
Хавсралт II. Дан тоололтын хүснэгт.....	67
Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 8-р хороо	114
Ховд аймаг	119
Архангай аймаг, Цахир сум	124
Дундговь аймаг, Дэлгэрцогт сум.....	129
Төв аймаг, Зүүнмод сум.....	134
Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сум.....	139

ДҮРСИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛ	8
ЗУРАГ 2 ОРОН НУТГИЙН ЗАСАГЛАЛЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫН ТАЛААР ӨГСӨН ИРГЭДИЙН ЗӨВ ХАРИУЛТЫН ТОО	14
ЗУРАГ 3 ОРОН НУТГИЙН ЗАСАГЛАЛЫН ТҮВШИН ДЭХ ЗАСАГ ДАРГА НАРЫН ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН МЭДЛЭГИЙН ТҮВШНИЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ХУВЬ	16
ЗУРАГ 4 ОРОН НУТГИЙН ЗАСАГЛАЛЫН ТҮВШИН ДЭХ ИТХ/ИНХ-ЫН ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН МЭДЛЭГИЙН ТҮВШНИЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ХУВЬ.....	16
ЗУРАГ 5 ТӨСВИЙН ТУХАЙ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААР МЭДДЭГ ИРГЭДИЙН ХУВЬ	18
ЗУРАГ 6 ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААР МЭДДЭГ ИРГЭДИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ЗӨВ ХАРИУЛТ ӨГСӨН ОРОЛЦОГЧДЫН ХУВЬ	19
ЗУРАГ 7 МЭДЭЭЛЛИЙН ГОЛЛОХ ТАВАН ЭХ СУРВАЛЖ ЗОРИЛТОТ БОЛОН ХЯНАЛТЫН БҮЛГЭЭР – ДАВТАН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭР	20
ЗУРАГ 8 ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ АВДАГ ЭХ СУРВАЛЖИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ ХУВИАР	21
ЗУРАГ 9 ОРОН НУТГИЙН ЗАСАГЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД НЬ ӨӨРСДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАДАГ ЭСЭХ ТАЛААРХ ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ	21
ЗУРАГ 10 ОРОН НУТГИЙН ЗАХИРГАА ӨӨРСДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАДАГ ГЭЖ ҮЗСЭН ИРГЭДИЙН ХУВЬ, ГАЗАР ЗҮЙН БАЙРШЛААР.....	23
ЗУРАГ 11 ОРОН НУТГИЙН ЗАХИРГАА ӨӨРСДИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАДАГ ГЭЖ ҮЗСЭН ИРГЭДИЙН ХУВЬ, ГАЗАР ЗҮЙН БАЙРШЛААР	23
ЗУРАГ 12 СҮҮЛИЙН НЭГ ЖИЛИЙН ХУГАЦААНД ОРОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ ТАРХААХ ТАЛААР ГАРГАСАН ЧАРМАЙЛТ НЭМЭГДСЭН ЭСЭХ ТАЛААР ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ, ХУВИАР	24
ЗУРАГ 13 ОЛОН НИЙТИЙН УУЛЗАЛТ/ ХУРАЛ ЦУГЛААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН МЭДЛЭГ – ЗВӨХӨН ЗОРИЛТОТ БҮЛЭГ	25
ЗУРАГ 14 ОЛОН НИЙТИЙН УУЛЗАЛТ/ ХУРАЛ ЦУГЛААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН МЭДЛЭГ – ЗВӨХӨН ХЯНАЛТЫН БҮЛЭГ	25
ЗУРАГ 15 ИРГЭД ТӨРИЙН АЛБАН ХААГЧИДТАЙ УУЛЗАХ БОЛОМЖ ОЛГОДОГ МЭДДЭГ ОЛОН НИЙТИЙН УУЛЗАЛТЫН ТОО.....	26
ЗУРАГ 16 СҮҮЛИЙН 12 САРД БАГ/ХОРООНЫ ИРГЭДИЙН ХУРАЛД ОРОЛЦСОН ИРГЭДИЙН ТОО	26
ЗУРАГ 17 СҮҮЛИЙН 12 САРД БАГ/ХОРООНЫ ИРГЭДИЙН ХУРАЛД ОРОЛЦСОН УЛААНБААТАРААС СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ТОО.....	27
ЗУРАГ 18 БАГ/ХОРООНЫ ИРГЭДИЙН ХУРАЛД ОРОЛЦООГҮЙ ШАЛТГААН- ЗӨВХӨН ДАВТАН СУДАЛГАА.....	27
ЗУРАГ 19 БАГ/ХОРООНЫ ИРГЭДИЙН ХУРАЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ГОЛЛОХ 5 ЭХ СУРВАЛЖ	28
ЗУРАГ 20 ХУРАЛ ДЭЭР САНАЛАА ХЭЛСЭН ИРГЭДИЙН ТОО	29
ЗУРАГ 21 ХУРАЛЫН ҮЕЭР САНАЛЫГ НЬ АВЧ ХЭЛЭЛЦСЭН ОРОЛЦОГЧДЫН ТОО	30
ЗУРАГ 22 ОРОЛЦСОН ХУРАЛЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ.....	30
ЗУРАГ 23 ИРГЭДИЙН ХУРЛЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМУУД.....	31
ЗУРАГ 24 ХУРАЛЫН ЭЦСИЙН ШИЙДВЭРИЙГ ОЛЖ МЭДСЭН ОРОЛЦОГЧДЫН ТОО.....	32
ЗУРАГ 25 ИРГЭДИЙН ХУРАЛЫН ОРОЛЦОО БОЛОН ТӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ ОРОЛЦОГЧДЫН ҮНЭЛГЭЭ	33
ЗУРАГ 26 ШИЙДВЭР ГАРГАХДАА ИРГЭДИЙГ ОРОЛЦУУЛАХ ШААРДЛАГАТАЙ АСУУДЛУУД	34
ЗУРАГ 27 ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ШУУД ОРОЛЦОХОД ГАРДАГ БЭРХШЭЭЛҮҮД.....	35
ЗУРАГ 28 ТА АЛЬ НЭГ ӨӨР ОРОН НУТАГТ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ АМЖИЛТТАЙ ХАНГАЖ БУЙ ТОХИОЛДЛЫГ МЭДЭХ ҮҮ?	36
ЗУРАГ 29 ХЭН НЭГЭН ТАНАЙ ОРОН НУТАГТ ДЭЭРХТЭЙ АДИЛ ТӨСТЭЙ САНААЧЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮҮ?	38
ЗУРАГ 30 БУСАД ОРОН НУТГИЙН ТУРШЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ ШАЛТГААН	38
ЗУРАГ 31 СҮҮЛИЙН 12 САРД ОРОН НУТГИЙН ЗАХИРГААНД ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГАРГАСАН ИРГЭДИЙН ТОО	39
ЗУРАГ 32 ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ГАРГААГҮЙ ШАЛТГААН	40
ЗУРАГ 33 ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ГАРГАСАН АРГА ЗАМ.....	40
ЗУРАГ 34 ТАНД ОРОН НУТГИЙН ЗАХИРГААНААС ХЭД ХОНОГИЙН ДАРАА ХАРИУ ӨГСӨН БЭ?.....	41
ЗУРАГ 35 САНАЛ, ХҮСЭЛТ ГАРГАЖ БУЙ ХУВЬ ХЭМЖЭЭ	41

ЗУРАГ 36 ӨМНӨХ ЖИЛТЭЙ ХАРЬЦУУЛАХАД ОРОН НУТГИЙН УДИРДЛАГЫН ИРГЭДИЙН САНАЛ, ХҮСЭЛТ, ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВАХ ХАНДЛАГАД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН УУ?	42
ЗУРАГ 37 ОРОН НУТГИЙН ЗАХИРГААНД ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ГАРГАСАН ИРГЭДИЙН ОРОН НУТГИЙН ХАНДЛАГЫН ТАЛААРХ ҮНЭЛГЭЭ.....	42
ЗУРАГ 38 ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТАЛААРХ СУУРЬ БОЛОН ДАВТАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН	43
ЗУРАГ 39 ИРГЭДИЙН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТӨВШИН – ДАВТАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН ЗОРИЛТОТ БОЛОН ХЯНАЛТЫН БҮЛГЭЭР	43
ЗУРАГ 40 ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРОН НУТГИЙН АШИГ СОНИРХОЛТОЙ ХАМААРАЛТАЙ БАЙДАЛ	46
ЗУРАГ 41 HAS FOCЕ’S SUPPORT CHANGED THE WAY PUBLIC CONSULTATION IS CONDUCTED?	47
ЗУРАГ 42 ТА ӨӨРИЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХДЭЭ ТӨСЛИЙН БОЛОВСРУУЛСАН ХЭВЛЭМЭЛ МАТЕРИАЛ, ТАЙЛАН ЭСВЭЛ МЕДИА МАТЕРИАЛЫГ АШИГЛАДАГ УУ?	48
ЗУРАГ 43 ОРОН НУТГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ТӨСЛИЙН ШУУД ДЭМЖЛЭГИЙН АЛИЙГ НЬ ТА ХАМГИЙН ЧУХАЛ ГЭЖ ҮНЭЛЭХ ВЭ?	49

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 3 ДАВТАН СУДАЛГААНЫ ЗОРИЛТОТ БОЛОН ХЯНАЛТЫН БҮЛГИЙН ҮР ДҮНГИЙН ЯЛГААНД ХИЙГДСЭН ХАМААРАЛГҮЙ ТҮҮВЭРТ Т-ТЕСТИЙН (Т УТГА) ҮР ДҮН	17
ХҮСНЭГТ 4 ДАВТАН СУДАЛГААНЫ ХЯНАЛТЫН БҮЛГИЙН ОРОЛЦОГЧДЫН МЭДЛЭГИЙН ТҮВШИН БОЛОН ОРЛОГЫН ТҮВШИНД ХИЙСЭН Т-ТЕСТИЙН ҮР ДҮН (Т УТГА)	18
ХҮСНЭГТ 5 ХУРЛЫН ЭЦСИЙН ШИЙДВЭРИЙН ТАЛААР ОЛЖ МЭДСЭН ОРОЛЦОГЧДЫН ТОО, ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР	32
ХҮСНЭГТ 6 БУСАД ТУРШЛАГЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВСАН ЭХ СУРВАЛЖ	37

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МАН	Монгол Ардын Нам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
НҮБХАС	Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүн амын сан
ТББ	Төрийн бус байгууллага

ХУРААНГУЙ

Энэхүү тайлан Орон Нутгийн Түвшинд Иргэдийн Оролцоог Нэмэгдүүлэх (ОНТИОН) төслийн төгсгөлийн судалгааны үр дүнг танилцуулна. Азийн Сан ОНТИОН төслийг 2013 оны 1-р сараас 2015 оны 3-р сарын хооронд Монгол улсын хэмжээнд нийт 17 туршилтын талбарт хэрэгжүүлсэн. ОНТИОН төслийн ерөнхий зорилго орон нутгийн захиргааны бодлого боловсруулалт, шийдвэр гаргах үйл явц дахь нийгмийн хариуцлага болон иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

2012 оны 12-р сард 6 туршилтын, 2 хяналтын талбарт суурь судалгаа хийгдсэн. Туршилтын талбар дахь иргэдийн ойлголт мэдлэг, зан байдал, хандлага дахь өөрчлөлтийг тодорхойлох зорилгоор эдгээр газарт 2014 оны 11-р сард ижил судалгааны хэрэглэгдэхүүн бүхий төгсгөлийн судалгааг хийсэн. Судалгаанд санамсаргүй түүврийн аргаар сонгосон туршилтын талбар дахь 555 иргэн, хяналтын талбар дахь 171 иргэн хамрагдсан. Үүнээс гадна чанарын шинжтэй мэдээлэл цуглуулах зорилгоор 38 орон нутгийн захиргааны албан хаагчдаас ярилцлага авав. Судалгааны үр дүнг хураангуй дүгнэвэл:

Зорилтот үр дүн 1: Орон нутгийн захиргааны бүтэц зохион байгуулалт болон оролцооны хуулиудын ойлголт мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх, засаг захиргааны мэдээллийн ил тод байдлыг хангах

- **Орон нутгийн захиргааны хэрэгжүүлэх чиг үүргээс дор хаяж нэгийг нэрлэх чадвартай иргэдийн харьцаа хяналтын ба зорилтот талбаруудад 70 хувь хүрсэн байна.** Энэ үзүүлэлт нь хяналтын талбарт өссөн бол зорилтот талбарт өөрчлөгдөөгүй, суурь судалгааны үр дүнгээр зорилтот талбар дахь үзүүлэлт хяналтын талбараас 10 пунктээр илүү байсан. ОНТИОН төслийн хүрээнд Монголын үндэсний радио телевизээр хэрэгжүүлсэн иргэдийн ойлголт, мэдлэгийн түвшин нэмэгдүүлэх кампанит ажил хяналтын ба зорилтот хүн амд хүрсэн байх боломжтой хэдий ч хяналтын талбар дахь үзүүлэлт өсөх шалтгаан болсон мэдээллийн гол эх үүсвэр мөн эсэхийг батлах тодорхой мэдээлэл байхгүй байна.
- **Зорилтот талбар дахь иргэдийн засаг захиргааны чиг үүргийн талаарх дэлгэрэнгүй ойлголт мэдлэгийн түвшин хяналтын талбар дахь үзүүлэлттэй харьцуулахад мэдэгдэхүйц нэмэгджээ.** Зорилтот талбар дахь оролцогчдоос орон нутгийн захиргааны 7-12 чиг үүргийг (санамж авахгүйгээр) зөв нэрлэх чадвартай иргэдийн тоо суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад 13 пунктээр өссөн бөгөөд санамж авахгүйгээр нэрлэж чадах орон нутгийн захиргааны чиг үүргийн дундаж тоо 2.8-аас 4.4 болж өссөн. Энэ нь зөвхөн зорилтот талбар дахь иргэдэд чиглэсэн төвлөрсөн сургалт болон материал тараах ажлын нөлөө гэж таамаглаж байна.
- Төсвийн тухай хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг мэдэх иргэдийн нийт харьцаа нэмэгдээгүй ч зорилтот талбар дахь оролцогчдоос **Төсвийн тухай хуулиар зохицуулсан 2 болон түүнээс дээш ойлголт тайлбарлах чадвартай иргэдийн тоо суурь судалгааны үзүүлэлттэй харьцуулахад 45 пунктээр өссөн.** Энэ үзүүлэлт хяналтын бүлгийн хувьд өөрчлөгдөөгүй.
- **Зорилтот талбар дахь мэдээллийн адил тэгш хүртээмж нэмэгдсэн байна.** Суурь судалгааны үр дүнгээр илэрсэн өрхийн орлого болон ойлголт мэдлэгийн түвшний шууд хамаарал зорилтот талбарт буурсан байна. Хяналтын талбар дахь өрхийн орлогын

өндөр хэмжээ ба орон нутгийн захиргаа болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухайн хуулийн ойлголт мэдлэгийн түвшний шууд хамаарал өндөр хэвээр байна.

- **Зорилтот талбар дахь орон нутгийн захиргааны талаар мэдээллийн хүртээмж хяналтын талбартай харьцуулахад нэмэгдсэн байна.** Орон нутгийн захиргааны талаар мэдээллийн хүртээмж огт байхгүй гэж хариулсан оролцогчдын тоо зорилтот талбарт 13 хувиас 10 хувь болтол буурсан бол хяналтын талбарт энэ үзүүлэлт суурь судалгааны 9 хувиас төгсгөлийн судалгааны үр дүнгээр 16 хувь болж өсчээ. Үүнээс гадна, зорилтот талбарт 3 болон түүнээс дээш эх сурвалжаас мэдээлэл авсан оролцогчдын тоо суурь судалгаанд 7 хувь байсан бол давтан судалгаагаар 28 хувь болж өссөн байна.
- **Орон нутгийн захиргааны ил тод байдлын талаар олон нийтийн үзэл бодол хяналтын (9.6 хувь) болон зорилтот (8.4 хувь) талбаруудад ойролцоо хэмжээгээр сайжирсан хэдий ч санхүүгийн мэдээллийн тайлагнал хяналтын талбарт харьцангуй илүү сайжирчээ.** Давтан судалгааны үр дүнд хяналт болон зорилтот талбар дахь санхүүгийн тайлагналын талаар олон нийтийн үзлийн эерэг хандлага адилхан 43 хувь болсон байгаа нь хяналтын талбар дахь мэдэгдэхүйц өсөлтийг илэрхийлж байна. Хяналтын болон зорилтот бүлгийн судалгааны үр дүн нийцэж байгаа нь ОНТИОН төсөл гэхээс илүү төв засгийн газраас Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн талаар ойлголт мэдлэгийн түвшин нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дүн байж болох юм.
- **Зорилтот талбарууд дахь ил тод байдлын газарзүйн ялгаа жигдэрчээ.** Ил тод байдлын талаар олон нийтийн үзэл зорилтот бүлгийн хот, хот орчмын талбарт мэдэгдэхүйц сайжирсан байна. Суурь судалгааны үр дүнд оролцогчдын үзэж байгаагаар ил тод байдлын түвшин сумын төвүүдэд хотын талбаруудаас өндөр байсан бол төгсгөлийн судалгаанд зорилтот талбаруудад энэ ялгаа ажиглагдахгүй байна. Харин хяналтын талбаруудад энэ ялгаа байсаар байна. ОНТИОН төслийн хүрээнд хийгдсэн арга хэмжээ зөрүүг арилгахад хувь нэмэр оруулсан байж болох юм.

Зорилтот үр дүн 2: Засаг захиргааны хурал уулзалт дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

- **Баг хорооны хурал уулзалт дахь иргэдийн оролцоо суурь судалгааны 28 хувиас ойролцоогоор 43 хувь болтол нэмэгдсэн байна.** Зорилтот (суурь судалгаанаас 14 хувь илүү) болон хяналтын (суурь судалгаанаас 17 хувиар илүү) талбар дахь үзүүлэлт ойролцоо өссөн ч хяналтын талбар дахь ирц үл ялиг илүү байна. Зорилтот болон хяналтын бүлгийн үр дүн ижил байгаа нь Сангийн яамны захирамжийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хурал уулзалтын ирцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дагавар байж болох юм. Гэхдээ үүнийг батлах тодорхой мэдээлэл байхгүй байна.
- **Суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад баг хорооны иргэдийн хурал уулзалтад сонирхолгүйн улмаас оролцоогүй иргэдийн тоо цөөрсөн бөгөөд зорилтот талбар дахь иргэдийн оролцоо сонирхол илүү нэмэгдсэн байна.** Суурь судалгаанд хамрагдсан оролцогчдын 30 хувь нь сонирхолгүй байсан тул хуралд оролцоогүй гэсэн бол төгсгөлийн судалгаанд энэ үзүүлэлт 15 хувь болтол буурсан байна. Энэ үзүүлэлт

хяналтын бүлгийн хувьд мөн буурсан ч арай бага хэмжээгээр буюу 10 хувиар буурсан байна.

- **Зорилтот талбар дахь иргэд хурал уулзалт хэзээ болох талаар мэдээлэл авах нь сайжирсан.** Суурь судалгааны үр дүнг харьцуулахад хурал уулзалт болох өдөр цагийн талаар мэдээлэл аваагүйгээс болж оролцож чадаагүй иргэдийн тоо зорилтот болон хяналтын бүлгийн хувьд ойролцоо (зорилтот 22 хувь ба хяналт 20 хувь тус тус) байв. Харин төгсгөлийн судалгаанд хангалттай мэдээлэл аваагүйн улмаас хуралд оролцож чадаагүй хяналтын бүлгийн иргэдийн тоо зорилтот бүлгээс хоёр дахин их байна. Орон нутгийн төрийн албан хаагчидтай уулзах боломж олгодог хурал уулзалтуудын талаарх ойлголт мэдлэгийн түвшин зорилтот талбарт нэмэгдсэн байна. Зорилтот талбарын оролцогчдын зөвхөн 5 хувь нь эдгээр хурал уулзалтуудын талаар “мэдэхгүй” гэсэн хариу өгсөн бол хяналтын талбар дахь үзүүлэлт 28 хувиас 39 хувь болтол өссөн байна.
- **Тэгсэн хэдий ч суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад хурал уулзалтын үер үг хэлж, санал хүсэлтээ илэрхийлэх нь багассан байна.** Энэ үзүүлэлт зорилтот болон хяналтын бүлэгт аль алинд буурсан байна. Гэхдээ нэг хяналтын талбарт хурал дээр саналыг нь авч хэлэлцсэн оролцогчдын эзлэх хувь зорилтот бүлгийн үзүүлэлтээс өндөр байв. Энэ үзүүлэлт зорилтот бүлэгт ерөнхийдөө буурсан бөгөөд үүнийг тайлбарлах мэдээлэл судалгааны өгөгдөлд байхгүй байна.
- **Зорилтот талбар дахь олон нийтийн хурал уулзалтад оролцсон иргэдийн хурлын үйл ажиллагааны сэтгэл ханамж 50 хувиас 60 хувь болж нэмэгдсэн байна.** Хяналтын талбар болох Говь-Угтаал сумд үүнээс илүү өсөлт гарсан бөгөөд орон нутгийн захиргааны хандлага нь гадны техникийн туслалцаанаас дутахгүй ач холбогдолтойг харуулж байгааг онцлох нь зүйтэй.
- **Олон нийтийн хурал уулзалтууд иргэдийн хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулж, хүн бүрт өөрийн үзэл бодлоо илэрхийлэж боломж олгодог гэсэн үзэлтэй зорилтот бүлгийн оролцогчдын хувь суурь судалгаанд 40 байснаа төгсгөлийн судалгаанд 50 болж өсчээ.** Харин хяналтын талбар болох Говь-Угтаал сумд үүнээс илүү өсөлт ажиглагдсан нь тухайн сумын онцлог шинжтэй холбоотой юм.

Зорилтот үр дүн 3: Туршилтын талбар хоорондын хөндлөн суралцах үйл явцыг өргөжүүлэх

Бусад орон нутгийн дадлага туршлага судлах, санаачлага авч хэрэгжүүлэх хэмжээнд өөрчлөлт гараагүй байна. Энэ нь ОНТИОН төслийн үйл ажиллагаа дундаж иргэдээс илүү орон нутгийн захиргааны албан хаагчдын хөндлөн суралцах арга хэмжээн дээр төвлөрөх болсонтой холбоотой юм. Ярилцлагад орсон 38 орон нутгийн төрийн албан хаагч хөндлөн суралцах арга хэмжээг төслийн жижиг түслэмжийн сангийн дараах хамгийн хэрэгтэй үйл ажиллагаа (судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 55 хувь) гэж үзсэн байна.

Зорилтот үр дүн 4: Нийгмийн хариуцлагын хэрэглэгдэхүүнийг хэрэгжүүлэх

ОНТИОН төслийн нийгмийн хариуцлагын онооны хуудас бөглөгдөж байх үед мэдээлэл цуглуулсан учраас үйл ажиллагаануудыг тусгаагүй байх магадлалтай. Энэ сэдвийн хүрээнд гарсан гол үр дүнгүүд:

- **Зорилтот талбар дахь оролцогчдын 42 хувь өмнөх жилтэй харьцуулахад орон нутгийн удирдлагын иргэдийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах хандлагад эерэг**

өөрчлөлт гарсан гэж үзсэн байна. 31 хувь нь хандлага өөрчлөгдөөгүй, 23 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (хяналтын талбарын үзүүлэлт гаргах мэдээлэл байхгүй байна).

- **Орон нутгийн захиргаанд гомдол гаргасан иргэдийн тоо бага зэрэг буурсан байна.** Суурь судалгааны үр дүнтэй адил, гомдол гаргаагүй оролцогчдын дийлэнх нь хандах асуудал байхгүй гэж хариулсан байна.
- **Санал хүсэлт, гомдол гаргах арга замуудын хувьд хяналтын талбартай харьцуулахад зорилтот талбарт утас болон и-мэйлээр хандах явдал бага зэрэг нэмэгдсэн** хэдий ч төрийн албан хаагчид шууд хандах нь хамгийн түгээмэл арга зам хэвээрээ байна.
- **Зорилтот талбар дахь санал хүсэлт, гомдолд хариу өгөх хугацаа ихэссэн** бөгөөд хяналтын талбарт хэвээрээ байна. Энэ үзүүлэлтийн өөрчлөлтийг тайлбарлах мэдээлэл асуумжид байхгүй байна.
- **Суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад үндсэн төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн түвшин бага зэрэг нэмэгдсэн байна** (төгсгөлийн судалгаанд төрийн үйлчилгээний сэтгэл ханамж “боломжийн” гэж хариулсан оролцогчдын тоо л илүү байсныг онцлох зүйтэй). Хяналтын талбар дахь оролцогчид зорилтот талбар дахь оролцогдоос харьцангуй илүү “сэтгэл маш ханамжгүй” гэж хариулсан байна. Үүнд орон нутгийн зам, байгаль хамгаалал (хяналтын талбарт 34 хувь сэтгэл маш ханамжгүй гэсэн бол туршилтын талбарт зөвхөн 6 хувь) ба олон нийтийн газрын тохижилт, засвар (дунджаар 19 хувь сэтгэл маш ханамжгүй гэсэн бол туршилтын талбарт зөвхөн 5 хувь) гэсэн үйлчилгээнүүд байна.

Ярилцлаганд орсон орон нутгийн захиргааны албан хаагчид төслийн хүрээнд хийгдэж буй хөндлөнгийн оролцоо нь орон нутгийн захиргааны шийдэх асуудлуудад чухал ач холбогдолтой байна; ОНТИОН төслийн дэмжлэгийн үр дүнд бодлогын өөрчлөлт хийгдэхийн зэрэгцээ иргэдийн оролцоог нэмэгдүүлэх санаачлагууд хэрэгжиж байна; жижиг тусламжийн механизм нь шинэчлэлд хамгийн чухал хүчин зүйл ч ОНТИОН төслийн дэмжлэгийн бүх л хэлбэр чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Хэдий тийм боловч судалгаанд хамрагдсан орон нутгийн захиргааны оролцогчдийн дийлэнх нь гадны дэмжлэггүй эдгээр шинэ санаачлагуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжгүй гэж хариулсан байна.

БҮЛЭГ I. ТАНИЛЦУУЛГА

Азийн Сан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газартай хамтран Швейцарийн Хөгжлийн Агентлагийн өгөөмөр санхүүжилтээр Орон Нутгийн Түвшинд Иргэдийн Оролцоог Нэмэгдүүлэх (ОНТИОН) төслийг хэрэгжүүлж байна. ОНТИОН төсөл нь Монгол Улсын Засгийн Газар төвлөрлийг сааруулах, ардчиллыг дэмжих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой Швейцарийн Хөгжлийн Агентлагийн Засаглалыг Дэмжих, Төвлөрлийг Сааруулах Хөтөлбөрийн (ЗДТСХ) бүрэлдэхүүн хэсэг юм. ОНТИОН төслийн ерөнхий зорилго орон нутгийн захиргааны бодлого боловсруулалт болон шийдвэр гаргах үйл явц дахь нийгмийн хариуцлага болон иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино. Төслийн зорилтот үр дүнгүүд:

- Засаглал дахь олон нийтийн оролцоог дэмжих хууль эрх зүйн тогтолцооны талаар ойлголт мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх
- Орон нутгийн захиргааны шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- Орон нутгийн захиргаа болон иргэдэд Монгол улсын бусад орон нутгийн дадлага туршлагаас суралцах боломжуудыг өргөжүүлэх
- Орон нутгийн захиргааны гол төрийн үйлчилгээ болон чиг үүргийн ил тод байдал болон хариуцлага хүлээх чадварыг нэмэгдүүлэх
- Иргэдийн орон нутгийн захиргаанд итгэх итгэл, сэтгэл ханамжийн ерөнхий түвшнийг нэмэгдүүлэх

Төслийн үйл ажиллагаа 2013 оны 1-р сард эхэлсэн бөгөөд 2015 оны 3 сард дуусна. Төсөлд нийт 17 туршилтын талбар хамрагдсан (6 аймгийн 14 сум бөгөөд Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3 хороо).¹ Төслийн хүрээнд зорилтот талбаруудыг сургалт, техникийн тусламж, бага хэмжээний мөнгөн тусламж болон хүний нөөцөөр хангасан. Төслийн нөөцийг 6 “жишиг сум”-д төвлөрүүлсэн: Цахир сум, Архангай аймаг; 8-р хороо, Хан-Уул дүүрэг; Зуунмод сум, Төв аймаг; Ховд хот, Ховд аймаг; Эрдэнэцагаан сум, Сүхбаатар аймаг; Дэлгэрцогт сум, Дундговь аймаг.

Төслийн хүрээнд зорилтот үр дүнтэй зэрэгцүүлэн харилцан бие биенээ бататгах үйл ажиллагааны дөрвөн ангилалд багтах үйл ажиллагаануудыг (өгөгдөл) хэрэгжүүлсэн:

1. **Иргэний Боловсрол (ИБ)** – олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад харилцаан холбооны хэлбэрүүд, төвлөрлийг сааруулах хууль журмын талаар иргэдийн ойлголт мэдлэгийн түвшнийг нэмэгдүүлэх сургалт болон бусад арга хэмжээ. Үүнээс гадна орон нутгийн захиргааны мэдээллийн нээлттэй хүртээмжийг дэмжих үйл ажиллагаанууд багтана.
2. **Иргэдийн Оролцоотой Шийдвэр Гаргалт (ИРШГ)** – ОНТИОН төслийн хүрээнд сургалт болон бага хэмжээний мөнгөн тусламжийн санхүүжилтээр орон нутгийн ард иргэдийг олон нийтийн зөвлөгөөнд хамруулсан. Эдгээр уулзалтын хэлэлцэх асуудлыг орон нутгийн ард иргэд сонгосон бөгөөд зөвлөгөөний түгээмэл сэдвүүдээр төрийн үйлчилгээ болон хөтөлбөрүүдийн чанар ба Орон Нутгийн Хөгжлийн Сангийн жил тутмын зөвлөгөөн байсан байна.
3. **Хөндлөн Суралцах (ХС)** – Тухайн орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээний дадлага туршлага болон ололт амжилтыг баримтжуулан бусад талбаруудад тараан мэдээллээр хангасан байна. ОНТИОН төсөл мөн бүс нутгийн болон үндэсний байнгын хурал уулзалт зохион байгуулж, төвлөрлийг сааруулах, оролцоог дэмжих дадлага туршлагыг Монголд бий болгохыг дэмжсэн байна.

¹ Төслийн талбаруудын ойролцоогоор хагас нь 2013 оны 7-р сараас хойш хамрагдсан тул 10 талбарт хийгдсэн бодит үйл ажиллагааны хугацаа 2 жил хүрэхгүй юм.

4. **Хяналт-Үнэлгээний Нийгмийн Хариуцлагын Хэрэглэгдэхүүн (ХҮНХХ)** – ОНТИОН төсөл нь орон нутгийн үйлчилгээний чанарын талаар санал хүсэлт авах үйл ажиллагааг дэмжиж, тухайн мэдээллийг орон нутгийн захиргааны бодлогыг өөрчлөхөд ашиглахыг дэмжсэн байна.

Төслийн эхэнд 2012/2013 он шилжих өвөл хийгдсэн суурь судалгаа иргэдийн хандлага, ойлголт мэдлэгийн түвшин болон орон нутгийн захиргааны шийдвэр гаргах үйл явц ба төрийн бодлого болон хөтөлбөрүүдийн талаар олон нийтийн санал бодолд нөлөөлөх оролцооны түвшин зэрэг үзүүлэлтүүдийг хэмжсэн. Суурь судалгааны үр дүнг иргэдийн ойлголт мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх кампанит ажлыг зохион байгуулахад ашиглахын зэрэгцээ төсөлд хамрагдсан орон нутгийн захиргаануудад өөрсдийн сул болон давуу талуудыг баримтжуулах зорилгоор өгсөн. ОНТИОН төсөл сүүлийн шатандаа орж байгаа учраас энэ тайлан 2014/2015 он шилжих өвөл хийгдсэн төгсгөлийн судалгааны үр дүнг танилцуулна. Судалгааны өгөгдөл болон бусад мэдээллийг суурь судалгааны жишиг 6 сум болон 2 хяналтын талбараас мөн ижил судалгааны хэрэгсэл ашиглан цуглуулсан бөгөд хандлага, ойлголт мэдлэг болон зан байдлын өөрчлөлтийг хэмжих зорилготой байв.

Тайлан дараах зохион байгуулалттай: 2-р бүлэгт аргачлалын талаар тайлбарласан. Судалгаанд оролцогчдын шинж чанаруудыг 3-р бүлэгт танилцуулсан. 4-р бүлэг иргэдийн судалгаа болон асуумжийн үр дүнг нэгтгэх бөгөөд зорилтот үр дүнд хүрэх төслийн ашигт ажиллагааг тоо баримтаар илэрхийлнэ. 5-р бүлэгт орон нутгийн захиргааны төлөөлөгчидтэй хийсэн ярилцлагаас авсан чанарын шинжтэй үр дүнг танилцуулна. Төгсөлд нь 6-р бүлэг тайлангийн дүгнэлтийг агуулна. Тайлангийн хавсралт нь судалгааны асуумж, төсөлд хамрагдсан талбаруудын дэлгэрэнгүй мэдээлэл болон судалгааны үр дүнг үнэлэхэд дөхөм болгох зорилготой талбаруудын онцлог шинжүүдийг тэмдэглэсэн хяналтын самбаруудыг агуулна.

БҮЛЭГ II. АРГА ЗҮЙ

Судалгааны үндсэн зорилго

Төгсгөлийн үнэлгээний (судалгаа) үндсэн зорилго нь “Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх” төслийн үр дүнг хэмжих явдал юм. Үүнтэй уялдан дараах зорилтууд нь судалгааны нэг хэсэг болон дэмшигдсэн болно:

1. ОНТИОН хөтөлбөрийн үйл ажиллагааны үр нөлөө, үр дүнг үнэлэх хэрэгжилтийн дараах үнэлгээний мэдээллээр хангах;
2. Орон нутгийн засаглал, түүний шийдвэр гаргах явц, үйлчилгээний талаарх иргэдийн мэдлэг болон иргэдийн сэтгэл ханамжийн түвшин дэхь өөрчлөлтийг тогтоох;
3. Орон нутгийн засаглал, ТББ-үүдтай хамааралтай иргэдийн түршлага, хандлага болон сонголтуудад дүн шинжилгээ хийх замаар иргэдийн оролцооны түвшинг тодорхойлох;
4. Хөтөлбөртэй холбоотой амжилттай түршлагыг илрүүлэх.

Түүврийн хүрээ

Судалгаа нь Азийн сангийн “FOCE” төсөл хэрэгжих Улаанбаатар хотын 1 хороо, 5 сумын 554 иргэнийг хамруулсан ба хяналтын бүлгээр Улаанбаатар хотын 1 хороо, 1 сумын 171 респондентуудыг хамруулсан. Судалгааны үндсэн мэдээллийг 2014 оны 11-р сарын 1-ээс 11-р сарын 26-ны хооронд цуглуулсан.

Судалгааг санамсаргүй түүврийн арга ашиглан хийж гүйцэтгэсэн. Хамгийн сүүлийн үеийн мэдээлэл болох Үндэсний Статистикийн Газрын 2010 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс үзвэл хөтөлбөр хэрэгжиж байгаа орон нутгийн хүн амын тоо 29,509 байв. Судалгаанд хамрагдах түүврийг сонгохдоо дээрх тоонд үндэслэн дараах томъёогоор судалгааны төлөөлөх чадварыг гаргасан.

$$n = \frac{\frac{z^2 \cdot p \cdot (1-p)}{c^2}}{1 + \frac{\frac{z^2 \cdot p \cdot (1-p)}{c^2} - 1}{N}}$$

- z = *Z* утга (тухайлбал, 95 хувийн итгэх түвшинтэй 1.96 итгэх завсартай),
 p = сонголт хийх хувь, энгийн бутархайгаар илэрхийлэгдэнэ (0,5-алдааны хязгаартай)
 c = магадлалын интервал, энгийн бутархайгаар (ж., .1 = ±5)
 N = тухайн газрын хүн амын тоо

Тоцооллын дүнд санал болгох нийт түүврийн хэмжээ 734 байснаас 555 нь зорилтот бүлэг, харин 179 нь хяналтын бүлгийн хүн ам байв. Хүснэгт нэгээс талбар бүрийн түүврийн мэдээллийг харна уу.


Хүснэгт 1 Судалгааны түүврийн хэмжээ

№	Судалгаа авсан газрууд	Орон нутаг	Төлөвлөсөн түүврийн хэмжээ	Бодит түүврийн хэмжээ	Төрийн албан хаагчид
Зорилтот бүлэг					
1	Улаанбаатар (Хан-Уул дүүрэг)	8-р хороо	95	100	5
2	Төв аймаг (Зуунмод сум)	Аймгийн төв	95	95	5
3	Ховд аймаг (Жаргалант сум)	Аймгийн төв	96	95	3
4	Архангай аймаг (Цахир сум)	Сумын төв	89	89	3
5	Сүхбаатар аймаг (Эрдэнэцагаан сум)	Сумын төв	94	94	3
6	Дундговь аймаг (Дэлгэрцогт сум)	Сумын төв	86	86	3
Хяналтын бүлэг					
1	Дундговь аймаг (Говь- Угтаал сум)	Сумын төв	85	86	0
2	Улаанбаатар (Сүхбаатар дүүрэг)	5-р хороо	94	99	0
Нийт			734	743	24

Хяналтын бүлгийг сонгохдоо, дараах шалгууруудыг баримталсан. Үүнд:

- Судалгаа хийх газар нь ижил төстэй байх;
- Үр дүнд харьцуулалт хийх зорилгоор бусад байгууллагын ижил төстэй төсөл, хөтөлбөрт хамрагдсан газруудыг оруулаагүй (Мэрсис Кор Монгол ОУБ-ын APREAL төсөл);
- Судалгааны газруудтай газар зүйн хувьд ойр байрлах.

Зураг 1. Судалгааны чиглэл



Мэдээлэл цуглуулах арга

Судалгаанд дараах мэдээлэл цуглуулах аргуудыг ашиглав:

1. Хагас бүтэцчилэгдсэн ярилцлага

Хагас бүтэцчилэгдсэн ярилцлага нь ОНТИОН төсөл хэрэгжсэн орон нутгийн төрийн албан хаагчидтай хийгдсэн. Ярилцлага нь төслийн явцад авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үялдаа холбоот байдал, үр дүнтэй байдал, үр ашигтай байдал болон тогтвортой байдлын талаар чанарын мэдээлэл цуглуулахад чиглэсэн. Судалгааны зорилтот талбар бүрт 5-7 орон нутгийн төрийн албан хаагчтай хагас бүтэцчилэгдсэн ярилцлага хийгдсэн. Ярилцлага бүр 30-40 минут үргэлжилсэн. Нийт 42 хагас бүтэцчилэгдсэн ярилцлага хийгдсэн. Ярилцлагын удирдамжийг Хавсралт нэгээс харна уу. Хяналтын бүлгийн хувьд эдгээр ярилцлагууд хийгдээгүй болно. Судалгааны талбар бүрт дараах албан хаагчдыг сонгож ярилцлага хийсэн:

- **Төрийн албан хаагч:** Орон нутгийн засаг дарга, Засаг даргын Тамгын Газрын дарга, ИТХ-ын дарга болон ИТХ-ын гишүүд.

2. Асуулга

Судалгааны гол аргуудын нэг нь хөтөлбөр хэрэгжиж буй газруудын иргэдээс санамсаргүй байдлаар сонгож авсан санал асуулгын судалгаа юм. Эхлээд санамсаргүй алхалтаар (3 айл тутмыг алгасах маягаар) өрхүүдийг сонгож баг, хорооны судалгаанд хамрагдах өрхүүдийг сонгосон. Өөрөөр хэлбэл, гудамж бүрт гурван өрх тутмын нэг нь судалгаанд хамрагдсан. Респондент асуулга өгөхөөс татгалзсан тохиолдолд дараагийн гуравдахь өрхөөс асуулга авахарга хэрэглэсэн.

Ихэнх нь хаалттай асуултаас бүрдэх стандартын санал асуулга ашигласан.. Судлаачид иргэдэд асуулт тавьж, өөрсдөө бөглөсөн. Асуулга нь нийгэм-хүн ам зүйн мэдээлэл, иргэний ухамсар, ойлголт, иргэдийн оролцоо, харилцан суралцах болон иргэдийн төрийн захиргаанд мэдүүлдэг санал хүсэлт зэрэгсэдвүүдийг хамарсан. Нэг асуулга ойролцоогоор 30 минут үргэлжлэв. Асуулгыг Хавсралт 1-д оруулсан.

3. Баримт бичгийн шинжилгээ

Баримт бичгийн шинжилгээ нь хүн ам зүй, орон нутгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, улс төрийн оролцоо зэрэг холбогдох статистик тоо баримт цуглуулахад ашиглав.

Мэдээллийн шинжилгээ

Судалгааны мэдээллийг хоёр мэдээлэл оруулагч Microsoft Excel програм руу оруулж, дараа нь хэвлэгдсэн судалгааны асуулгуудтай тулгаж алдааг зассан. Мэдээллийг SPSS 17.0. програм руу хөрвүүлсэн. Арга хэрэгслийг шинжлэх болон хоёр категорын хамаарлыг ки квадратшалгахдаа 95 хувийн магадлалын түвшинг ашигласан.

Чанарын судалгааны мэдээллийн хувьд дуу хураагуураар ярилцлагыг бичиж авсан. Чанарын судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ хоорондоо хамааралтай сэдвүүдийг нэгтгэх үүднээс хэв маяг үүсгэх зэрэг аргыг ашигласан. Ингэхдээ чанарын судалгааны програм болох QDA miner-ийг ашигласан. Үүний дараа тоон мэдээлэл боловсрогдон гарч ирж, тэдгээрийг зохион байгуулалтад оруулж, уг интерактив судалгаанаас бий болсон мэдээллээс дараагийн сэдэв, загваруудыг тодорхойлсон.

Мэдээлэл цуглуулалтын явцад тулгарсан асуудлууд

Мэдээлэл цуглуулах явцад дараах асуудлууд тулгарсан. Үүнд:

- Нэгдүгээрт, судалгаанд хамрагдаж асуулга өгсөн иргэдийн тоо төлөвлөсөн түвшингээс доогуур байсан. Ойролцоогоор санамсаргүй сонгосон хоёр өрх (иргэн) тутмын нэг нь асуулга өгөхөөс татгалзсан эсвэл өгөх боломжгүй байв (зарим айлд насанд хүрсэн хүн байхгүй, г.м.). Урамшуулал өгөөгүй нь иргэд судалгаанд оролцохоос татгалзсан гол шалтгаан байв. Үүнээс гадна иргэдийн судалгаанд оролцоогүй бусад шалтгаанууд нь завгүй, судалгаанд хамрагдах сонирхолгүй, өөрсдийн эрүүл мэнд болон ахуй амьдралынхаа талаар мэдээлэл өгөх хүсэлгүй явдлууд байв. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийнхөө талаар ярих сонирхолгүй байсан. Гэсэн хэдий ч, талбарын судлаачид түүврийн тоог гүйцээхийн тулд өрхүүдээр дахин орж эдгээр бэрхшээлүүдийг даван туулсан
- Хоёрдугаарт, судалгаа хамгийн хүйтэн улиралд явагдсан. Цасан шуурга тавьж, зарим зарим газар зам хаагдаж байсан нь мэдээлэл цуглуулах хугацааг удаашруулсан.

Судалгааны хязгаарлагдмал тал

Дээрх асуудлууд болон бусад хүчин зүйлүүдээс үүдэн анхаарлаад авбал зохих дараахь хязгаарлалтуудтай тулгарсан. Үүнд:

- Судалгаа нь үндэсний хэмжээнд төлөөлөх боломжтой түүврээс мэдээлэл цуглуулах зорилго тавиагүй, суурь судалгаа зориуд сонгосон цөөн тооны судалгааны талбарыг хамруулсан бөгөөд төгсгөлийн үнэлгээ нь эдгээр талбаруудад хийгдсэн. Тиймээс, судалгааны дүн үндэсний хэмжээнд ерөнхий хандлага, дүр төрхийг харуулахаас илүүтэй тухайн баг, хорооны онцлогийг харуулсан.
- Судалгаа нь түүний зорилготой уялдан учир шалтгааныг тайлбарлахаас илүүтэй нөхцөл байдлыг тодорхойлох, илрүүлэхэд чиглэсэн.
- Уг судалгаанд санхүүгийн хязгаарлалтаас болж түүврийн магадлалын интервалыг арай их байхаар($\pm 5\%$) авсан. Энэ нь судалгааны үр дүнгийн магадлалын түвшинд зохих хэмжээгээр нөлөөлсөн байж болох талтай.
- Шаардлагатай зарим баримт бичгийг олж авахад хүндрэлтэй байсны улмаас баримт бичгийн судалгаа нь зөвхөн цөөн тооны баримт бичгээр хязгаарлагдсан.

Тайлангийн бүтэц

Тайлан нь 6 бүлэг болон 3 хавсралтаас (асуулга, дан тоололтын хүснэгтүүд, талбарын тусгайлсан үндсэн үзүүлэлт) бүрдэнэ. Бүлэг, дэд бүлэг бүрийн эхэнд хэлэлцэх агуулгын товч тайлбарыг оруулав.

- Суурь судалгааны үр дүнг суурь судалгаа болон давтан судалгааны үр дүнгүүдийг харьцуулах, төслийн үр нөлөөг тогтоох зорилгоор төсөл хэрэгжиж буй болон хэрэгжээгүй (хяналтын бүлэг) газруудаар ангилан(зорилтот бүлэг) гаргасан. Хэдий тийм ч хяналтын талбарын цөөн (төсвийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 2 хяналтын талбар) учир хяналтын бүлэг нь аймгийн төлөөлөл гэж үзэх боломжгүй бөгөөд зөвхөн зорилтот бүлгийн үр дүнг харьцуулах, зэрэгцүүлэх зорилгоор авч үзсэн.
- Бараг бүх хариултуудыг нас, хүйс, боловсролын түвшин, ажлын эрхлэлт ба орлогоор нь ангилсан. Эдгээр үзүүлэлтүүдийг хавсралтад оруулав. Дэлгэрэнгүй тайланд, зөвхөн сонирхолтой эсвэл ач холбогдолтой үр дүнгүүдийг оруулсан. Тухайн асуулттай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл хавсралттай танилцаж болно.

БҮЛЭГ 3. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ОНЦЛОГ ШИНЖ ЧАНАР

Судалгаа нь Хан-Уул дүүргийн 8-р хороо, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум, Ховд аймгийн Ховд хот, Архангай аймгийн Цахир сум, Дундговь аймгийн Дэлгэрцогт сум болон Төв аймгийн Зуунмод сум мөн хяналтын бүсийн Сүхбаатар дүүргийн 13-р хороо (УБ) болон Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 18-аас дээш насны иргэдээс санамсаргүй сонгогдсон 743 иргэнийг судалгаанд хамруулсан болно. Судалгаанд хамрагдсан иргэдийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн зарим шинж байдлыг Хавсралт 2-т дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгтээс харахад тэд насны бүлгийн хувьд судалгааны зорилтот хүн амыг бүрэн төлөөлж байна. Харин хүйсийн хувьд судалгаанд хамрагдагсдын 44% нь эрэгтэй мөн 56% нь эмэгтэйчүүд хамрагдсан байв. Энэ нь судалгааны баг өрхийн гишүүдээс санамсаргүй түүврийн аргаар судалгаанд хамрагдагчдыг сонгосон, судалгаа авах цаг нь ажлын цагтай давхцаж байснаас эрэгтэйчүүд олонхи тохиолдолд эзгүй байсантай холбоотой юм. Судалгаа хийгдсэн газар бүрд судалгаанд оролцогчдын хүйсийг авч үзвэл Ховд аймгийн Ховд хотод хамгийн олон эрэгтэйчүүд (54%), Дундговь аймгийн Говь-Угтаал суманд хамгийн бага эрэгтэйчүүд (36%) судалгаанд хамрагдсан.

Боловсролын байдлаар авч үзвэл судалгаанд хамрагдагсдын 38% нь бүрэн дунд боловсролтой (9-11 анги), түүнчлэн 27% нь дээд боловсролтой, 20% нь бага боловсролтой (1-4 анги) бол 10% нь мэргэжлийн боловсролтой байв.

Ажил эрхлэлтийн хувьд нийт судалгаанд оролцогчдын 10% нь ажилгүй байв. Судалгаанд оролцогчдын дийлэнхи хувийг (23%) төрийн албаны ажил эрхлэгчид эзэлсэн байна. Судалгаанд хамрагдагсдын 19% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 14% нь өндөр настан бол 11% нь малчид тус тус хамрагдсан байна.

Эцсийн судалгааны түүврийг суурь судалгааны түүвэртэй харьцуулбал нас болон өрхийн орлогын түвшин гэсэн хоёр үзүүлэлтүүдийн хувьд ялгаатай байна. Эцсийн судалгааны түүвэр нь суурь судалгааны түүврийг бодвол насны хувьд өндөр, харин өрхийн орлогын түвшинг харах юм бол голдуу элбэг хүмүүс хамрагдсан байна (Хүснэгт2). Судалгааны үр дүнд эдгээр үзүүлэлтүүдийн ялгаа нь ямар нэгэн ач холбогдол бүхий нөлөө үзүүлээгүй юм.

Хүснэгт 2 Эцсийн болон суурь судалгааны түүврийн тус тусын үзүүлэлт

	Үзүүлэлт	Суурь судалгаа	Эцсийн судалгаа	Зөрүү	Statistical significance
ХҮИС НАС	18-21	8.0%	4.6%	-3.4%	Т утга = -2.481 Р утга = 0.13
	22-30	28.4%	24.1%	-4.3%	
	31-40	19.4%	23.3%	3.9%	
	41-50	21.7%	22.7%	1%	
	51-65	16.8%	20.1%	3.3%	
	65-ур	5.7%	5.2%	-0.5%	
ХҮЙС	Эрэгтэй	45.4%	43.7%	-1.7%	Т утга= - 0.631 Р утга= 0.528
	Эмэгтэй	54.6%	56.3%	1.7%	
БОЛОВСРОЛЫН ТҮВШИН	Боловсролгүй	1.4%	0.5%	-0.9%	Т утга= - 1.575 Р утга= 0.115
	Бага боловсрол /1-4 анги/	7.6%	4.3%	-3.3%	
	Суурь боловсрол /5-8 анги/	20.9%	20.3%	-0.6%	
	Бүрэн дунд боловсрол /9-11 анги/	33.3%	38.1%	4.8%	
	Мэргэжлийн	10.8%	9.7%	-1.1%	
	Их дээд сургууль	26.1%	27.1%	1%	
ӨРХИЙН ДУНДАЖИЛ ЭРХЛЭЛТ	Хувийн хэвшил	11.6%	9.8%	-1.8%	Т утга= 1.543 Р утга= 0.123
	Төрийн байгууллага	19.6%	23.4%	3.8%	
	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	18.1%	18.6%	0.5%	
	Малчин	9.7%	11.0%	1.3%	
	Өндөр настан	11.3%	14.4%	3.4%	
	Оюутан	6.4%	3.5%	-2.9%	
	Ажилгүй	21.6%	17.0%	-4.6%	
	Хөгжлийн бэрхшээлтэй	1.7%	2.3%	0.6%	
ӨРХИЙН ДУНДАЖИЛ ОРЛОГО /Төг/	200.000 хүртэлх	22.3%	13.1%	-9.2%	Т утга= - 3.816 Р утга= .000
	200.000-400.000	24.6%	25.8%	1.2%	
	400.000-600.000	23.1%	23.3%	0.2%	
	600.000-800.000	12.7%	15.5%	2.8%	
	800.000-аас дээш	12.7%	18.7%	6%	
	Орлогогүй	4.7%	3.6%	-1.1%	

БҮЛЭГ IV. ИРГЭДИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэ бүлэгт дараах дөрвөн сэдвийг хамарсан иргэдийн судалгааны үр дүнг танилцуулна:

- Иргэдийн ойлголт мэдлэгийн түвшин (жишээ нь орон нутгийн захиргааны чиг үүрэг болон иргэдийн оролцооны хууль эрх зүйн тогтолцоо)
- Орон нутгийн хэмжээн дэх иргэдийн оролцооны түвшин
- Монгол улсын бусад орон нутгийн иргэдийн оролцооны загвар, дадлага туршлагын талаар ойлголт мэдлэгийн түвшин (хөндлөх суралцах)
- Нийгмийн хариуцлагын арга хэмжээний талаар ойлголт мэдлэгийн түвшин болон орон нутгийн төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн түвшин

Иргэдийн судалгааны зорилго нь зорилтот буюу төслийн арга хэмжээ авсан талбар дахь ойлголт мэдлэг, иргэдийн оролцоо, хөндлөн суралцах байдал болон нийгмийн хариуцлагын түвшин суурь судалгааны үр дүнгээс хэрхэн өөрчлөгдсөнийг тогтоохын зэрэгцээ хяналтын талбарын судалгааны үр дүнтэй харьцуулан ОНТИОН төслийн хөндлөнгийн оролцооны нөлөөг тодорхойлоход оршино. Үүнтэй холбоотойгоор, тайлангийн энэ бүлэг нь дээр дурьдсан сэдвүүдийн бүртгэгдсэн өөрчлөлтүүдийг хэлэлцэхийн зэрэгцээ судалгааны тогтолцооны хязгаарлалтуудын хүрээнд суурь судалгаа болон давтан судалгааны ялгаатай болон төстэй үр дүнд нөлөөлөх хүчин зүйлсийн дүн жинжилгээ болон баримт үндэслэлийг тайлбарлах болно.

Энэ бүлэгт танилцуулсан иргэдийн судалгааны үр дүнг хоёр хүн амын бүлгийн ялгааг тодруулах зорилгоор зөвхөн зорилтот болон хяналтын бүлгээр задалж салгасан. Судалгааны бүх асуултын давтамжийн хүснэгт бүхий Хавсралт 2 болон зорилтот талбар болгоны хяналтын самбар бүхий Хавсралт 3-т талбар болгоны дэлгэрэнгүй үр дүнтэй танилцаж болно.

1. Ойлголт мэдлэгийн түвшинд гарсан өөрчлөлтүүд

ОНТИОН төслийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон орон нутгийн түвшинд төрийн бодлого болон хөтөлбөрүүдийн талаар олон нийтийн санал бодолд нөлөөлөх иргэдийн оролцооны жишээнүүдийг үндэсний телевиз болон радиогоор сурталчлан таниулах кампанит ажлууд багтсан. Баримтат кино, богино хэмжээний сурталчилгаа, болон олон нийтийн үйлчилгээний зарлал буюу шторкуудыг үндэсний сувгаар (Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз) удаа дараа цацсан нь зорилтот болон хяналтын талбарууд дахь үзэгчдэд зэрэг хүрсэн. Туршилтын талбар дахь иргэдэд чиглэсэн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн сургалт зохион байгуулагдахын зэрэгцээ Төсвийн тухай хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн талаар зурагт хуудас, брошүр болон бусад хэвлэмэл материал тараасан бөгөөд хяналтын талбарт эдгээр арга хэмжээг аваагүй юм.

Ойлголт мэдлэгийн ерөнхий түвшин²


Суурь судалгаанд хамрагдсан зорилтот талбар дахь нийт оролцогчдын ойролцоогоор 70 хувь нь орон нутгийн захиргааны дор хаяж нэг чиг үүрэг нэрлэж чадсан бол хяналтын талбарт энэ үзүүлэлт дөнгөж 60 хувь байна. Төслийн арга хэмжээнд хамрагдсан талбарууд дахь ойлголт мэдлэгийн ерөнхий түвшин өөрчлөгдөөгүй харин хяналтын талбар дахь ойлголт мэдлэгийн ерөнхий түвшин зорилтот талбар дахь түвшинтэй зэрэгцэх хэмжээнд очиж нэмэгдсэнийг Зураг

² Энэ хэсэгт орон нутгийн засаглалын гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагуудын чиг үүргийн талаар ойлголт мэдлэгийн түвшин тогтоох судалгааны асуултуудын үр дүнг хэлэлцэнэ (Хавсралт 1 дэх асуумжийн 9-14 асуултууд)

2-оос харах боломжтой. Одоогийн байдлаар зорилтот болон хяналтын бүлгийн оролцогчдын орон нутгийн захиргааны дор хаяж нэг чиг үүрэг нэрлэж чадах иргэдийн тоо ижил 70 хувь орчим байна (хяналтын талбарт статистикийн хувьд мэдэгдэхүйц буюу 9 хувийн өсөлт ажиглагдсан байна.)

Үлдсэн 30 хувь буюу орон нутгийн захиргааны нэг ч чиг үүрэг зөв нэрлэж чадахгүй оролцогчдын тоо зурагт үзэх боломжгүй эсвэл иргэний асуудалд огт сонирхолгүй хүн амын бүлгийг илэрхийлж байгаа эсэхийг судалгааны үр дүнгээр тайлбарлах боломжгүй юм.

Зураг 2 Орон нутгийн засаглалын үүрэг, хариуцлагын талаар өгсөн иргэдийн зөв хариултын тоо ³



Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Тэмдэглэл: Судалгаанд хамрагдсан оролцогчдоод тооллого хийж буй судалгааны ажилтан ямар ч сануулга өгөлгүйгээр орон нутгийн захиргааны чиг үүрэг нэрлэхийг асуусан.


Тэгсэн хэдий ч хяналтын талбаруудтай харьцуулахад зорилтот талбар дахь иргэдийн ойлголт мэдлэгийн агуулга болон чанар нэмэгдсэн байна. Зорилтот талбар дахь оролцогчдоос орон нутгийн захиргааны 7-12 чиг үүргийг зөв нэрлэх чадвартай иргэдийн тоо суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад 13 хувиар өссөн бөгөөд нэрлэж чадах орон нутгийн захиргааны чиг үүргийн дундаж тоо суурь судалгааны 2.8-аас 4.4 болж өссөн байна. Оролцогчдын мэдлэгийн чанарын өсөлт нь статистикийн хувьд мэдэгдэхүйц байна (статистикийн т утга=-7.049). Энэ нь зөвхөн зорилтот талбар дахь иргэдэд чиглэсэн төвлөрсөн сургалт болон материал тараах ажлын нөлөө гэж таамаглаж байна. Регрессийн буюу хувьсагчдын хоорондын хамаарлын шинжилгээ хийхэд оролцогчдын байршил, хүйс болон орлогын түвшин ба ойлголт мэдлэгийн түвшний хооронд мэдэгдэхүйц харилцан хамаарал илрээгүй байна.

Орон нутгийн захиргааны гүйцэтгэх засаглалын хариуцлагын талаар ойлголт мэдлэгийн түвшин

Дээрх үр дүнг задлан салгах явцад, эхний ээлжинд гүйцэтгэх засаглалын талаар ойлголт мэдлэгийн түвшнийг авч үзсэн байна. Үүнд аймаг, сум, дүүрэг, баг, хорооны түвшний орон нутгийн захиргааны тэргүүн буюу засаг даргын чиг үүрэг багтана. Зураг 3 гүйцэтгэх засаглалын талаар ойлголт мэдлэгийн түвшний талаар хийсэн судалгааны үр дүнг харуулна.

³ Аймаг/ нийслэл, сум/дүүрэг, баг/ хорооны түвшний хууль тогтоох ба гүйцэтгэх засаглалын байгууллагуудын үүрэг, хариуцлагын талаарх иргэдийн мэдлэгийн нэгдсэн түвшин

Зураг 3 Орон нутгийн засаглалын түвшин дэх засаг дарга нарын чиг үүргийн талаарх иргэдийн мэдлэгийн түвшний өөрчлөлтийн хувь



Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743


Зорилтот бүлгийн оролцогчдын ойлголт мэдлэгийн түвшинд мөн чанарын өөрчлөлт илэрсэн байна. Зорилтот бүлгийн оролцогчдын орон нутгийн захиргааны гүйцэтгэх засаглалын талаар ойлголт мэдлэгийн агуулга болон чанар хяналтын бүлгийн оролцогчдоос мэдэгдэхүйц илүүгээр нэмэгдсэн байна.

Хяналтын бүлгийн оролцогчдын баг/хорооны засаг даргын чиг үүргийн талаар ойлголт мэдлэгийн түвшин буурсан байна. Баг/хороо нь хамгийн их иргэдтэй шууд харьцах магадлалтай орон нутгийн захиргааны түвшин тул энэ үзүүлэлт буурсан нь зарим талаар сонин бөгөөд (олон нийтийн үүлзалт болон иргэдэд түгээх мэдээллийн дийлэнхийг хариуцдаг) хяналтын бүлгийн оролцогчдын ойлголт мэдлэгийн түвшин суурь судалгааны үзүүлэлтээс буурсан шалтгаан тодорхойгүй байна.

Орон нутгийн захиргааны хууль тогтоох засаглалын хариуцлагын талаар ойлголт мэдлэгийн түвшин

Хууль тогтоох засаглалын талаар ойлголт мэдлэгийн түвшинтэй холбоотой судалгааны үр дүн ерөнхий үр дүнтэй нийцэж байна. Зорилтот болон хяналтын бүлгийн иргэдийн орон нутгийн захиргааны хууль тогтоох засаглалын хариуцлага болон чиг үүргийн талаар ойлголт мэдлэгийн түвшин нэмэгдсэнийг Зураг 4 харуулж байна.

Зураг 4 Орон нутгийн засаглалын түвшин дэх ИТХ/ИНХ-ын чиг үүргийн талаарх иргэдийн мэдлэгийн түвшний өөрчлөлтийн хувь



Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Зорилтот талбар дахь мэдлэгийн дундаж түвшин хяналтын талбараас өндөр бөгөөд энэ зөрүү нь статистикийн хувьд мэдэгдэхүйц байгааг Хүснэгт 3 харуулж байна.

Хүснэгт 1 Давтан судалгааны зорилтот болон хяналтын бүлгийн үр дүнгийн ялгаанд хийгдсэн Хамааралгүй түүвэрт Т-тестийн (t утга) үр дүн ⁴

	Гүйцэтгэх	Хууль тогтоох
Аймаг/нийслэл	1.342	3.585
Сум/дүүрэг	2.93	4.657
Баг/хороо	7.426	7.482

Зорилтот болон хяналтын бүлгийн оролцогчид хууль тогтоох засаглалаас илүү гүйцэтгэх засаглалын талаар ойлголт мэдлэг өндөр байгаа нь суурь судалгааны үр дүнтэй нийцэж байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хариуцлага болон чиг үүргийн талаар ойлголт мэдлэгтэй иргэдийн тоо (20.3 хувь) орон нутгийн засаг даргын хариуцлага болон чиг үүргийн талаар ойлголт мэдлэгтэй оролцогчдын тооноос ерөнхийдөө мэдэгдэхүйц бага байна.

Суурь судалгаанд орон нутгийн захиргааны чиг үүргийг “мэдэхгүй” гэж хариулсан эмэгтэй оролцогчдын тоо эрэгтэй оролцогчдоос 10 хувиар илүү байсан бол төгсгөлийн судалгаанд зорилтот болон хяналтын талбарт аль алинд нь хүйс болон ойлголт мэдлэгийн түвшний хооронд мэдэгдэхүйц харилцан хамаарал илрээгүй байна.

Харин хяналтын талбарт өрхийн орлого болон ойлголт мэдлэгийн түвшний хооронд харилцан хамаарал илэрсэн бөгөөд зорилтот талбарт энэхүү харилцан хамаарал ажиглагдаагүй байна. Сарын 400,000 төгрөгөөс доош орлоготой иргэдийн орон нутгийн захиргааны хариуцлага болон чиг үүргийн талаар ойлголт мэдлэг сарын 400,000 төгрөгөөс дээш орлоготой оролцогчдын мэдлэгээс бага байгааг Хүснэгт 5 харуулж байна.

⁴ Хэрэв Т-утга нь 2-оос их байвал хоёр түүврийн хоорондын ялгаа нь статистикийн хувьд ач холбогдолтой байна.


Хүснэгт 2 Давтан судалгааны хяналтын бүлгийн оролцогчдын мэдлэгийн түвшин болон орлогын түвшинд хийсэн Т-тестийн үр дүн (t утга)

	Гүйцэтгэх	Хууль тогтоох
Аймаг/нийслэл	-3.869	-2.179
Сум/дүүрэг	-2.855	-3.088
Баг/хороо	-1.983	-2.715

Газарзүйн байршил болон оролцогчдын ойлголт мэдлэгийн түвшний хооронд ямар ч харилцан хамаарал илрээгүй нь суурь судалгааны үр дүнтэй нийцэж байна. Хэдий тийм боловч орон нутгийн захиргааны хариуцлага болон чиг үүргийн талаар ойлголт мэдлэгтэй сумын төвийн оролцогчдын тоо Улаанбаатар хот болон аймгийн төвийн үзүүлэлтээс өндөр байна (дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-оос авна үү).

Иргэдийн оролцооны хууль эрх зүйн тогтолцооны ойлголт мэдлэгийн түвшин Суурь судалгаанд иргэдийн оролцооны эрх зүйн үндэс олгох хууль тогтоомжийн ойлголт мэдлэгийн түвшин маш бага байсан. Зорилтот болон хяналтын талбар дахь оролцогчдын дунджаар 14 хувь Төсвийн тухай хууль, мөн дунджаар 9 хувь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн талаар мэдэж байв. Эдгээр үзүүлэлтүүдэд бодитой өсөлт гараагүйг Зураг 5 харуулж байна.

Зураг 5 Төсвийн тухай болон Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн талаар мэддэг иргэдийн хувь




Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Оролцогчдын Төсвийн тухай хуулийн мэдлэгийн түвшин зорилтот болон хяналтын талбарт буурсан байна (статистикийн алдаа гарах интервалд багтсан байна). Харин эсрэгээр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн талаар ойлголт мэдлэгийн түвшин хяналтын талбарт 13 хувиар, харин зорилтот талбарт зөвхөн 4 хувиар өссөн байна. Эдгээр үзүүлэлтийн өөрчлөлтийг тайлбарлах шалтгаан судалгааны мэдээлэлд байхгүй байна. Энэ хоёр хуулийн ойлголт мэдлэгийн түвшин болон газарзүйн байршил ба оролцогчдын хүйсийн хооронд мэдэгдэхүйц харилцан хамаарал илрээгүй байна. Харин давтан судалгаанд хамрагдсан өндөр орлоготой (сарын 400,000 төгрөгөөс дээш) иргэд Төсвийн тухай хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн талаар илүү мэдлэгтэй

байна (Төсвийн тухайн хуулийн хувьд t утга= -3.95, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хувьд t утга= -4.646).⁵

Суурь судалгаатай мөн адил Төсвийн тухай хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн талаар ойлголт мэдлэгтэй оролцогчдоос тухайн хуулиар зохицуулсан ойлголт нэрлэхийг асууж мэдлэгийн агуулга болон чанарыг тодорхойлсон. Төсвийн тухай хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн талаар ойлголт мэдлэгтэй оролцогчдын ерөнхий харьцаанд мэдэгдэхүйц өсөлт гараагүй ч (Зураг 5 харуулж байна), судалгаанд оролцогчдын мэдлэгийн агуулга болон чанар, ялангуяа зорилтот талбарт, нэмэгдсэнийг Зураг 6 харуулж байна.

Зураг 6 Төсвийн тухай хууль болон Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн талаар мэддэг иргэдийн хуулийн зохицуулалтын тухай зөв хариулт өгсөн оролцогчдын хувь



Мэдээллийн ил тод байдлын тухай хууль Суурь судалгаа N=69; Давтан судалгаа N=116
Төсвийн тухай хууль Суурь судалгаа N=100; Давтан судалгаа N=82

Суурь судалгаанд эдгээр хуулиар зохицуулсан хоёр болон түүнээс дээш ойлголт нэрлэх чадвартай хяналтын бүлгийн оролцогчдын тоо зорилтот бүлгийн үзүүлэлтээс үл ялиг өндөр байсан бол давтан судалгаанд зорилтот бүлгийн Төсвийн тухай хуулиар зохицуулсан хоёр болон түүнээс дээш ойлголт нэрлэх чадвартай оролцогчдын тоо 45 хувиар өсч харин хяналтын бүлгийн үзүүлэлт өөрчлөгдөөгүй байна. Зорилтот бүлгийн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар зохицуулсан хоёр болон түүнээс дээш ойлголт нэрлэх чадвартай оролцогчдын тоо өсч хяналтын бүлгийн түвшинд хүрсэн байна. Хэдий тийм боловч, Төсвийн тухай хуулиар зохицуулсан нэг ч ойлголт нэрлэж чадахгүй хяналтын бүлгийн оролцогчдын тоо мэдэгдэхүйц өссөн байна. Энэ нь хяналтын бүлгийн иргэд Төсвийн тухай хуулийн талаар мэдлэгтэй эсвэл нэрийг нь мэддэг хэдий ч тухайн хуулиар зохицуулсан ойлголтуудын талаар мэддэггүйг илтгэж байна.


Засаг захиргааны мэдээллийн хүртээмж

Суурь судалгаанд хамрагдсан оролцогчдоос засаг захиргааны асуудлын талаар мэдээллийг хаанаас авдаг болон хаанаас авахыг илүүд үздэг эх сурвалжуудын талаар асуусан. Энэхүү мэдээллийг иргэдийн ойлголт мэдлэгийн түвшин нэмэгдүүлэх кампанит ажил болон бусад

⁵ Төсвийн тухай хуулийн мэдлэг болон орлогын түвшний харилцан хамаарал зорилтот болон хяналтын талбарт ажиглагдсан бол Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн мэдлэг болон орлогын түвшний харилцан хамаарал зөвхөн хяналтын талбарт илэрсэн байна.

материал бэлдэхэд ашигласан байна. ОНТИОН төслийн хүрээнд орон нутгийн захиргаанд иргэдэд мэдээлэл түгээх болон иргэдээс санал хүсэлт авах зорилгоор бага хэмжээний мөнгөн тусламж өгсөн байна. Бага хэмжээний тусламжийн санг орон нутгийн улирал тутмын сонин, орон нутгийн радио телевизээр мэдээлэл цацах, мэдээллийн самбарыг хөл хөдөлгөөн ихтэй газар байрлуулах⁶, мэдээллийн самбар дахь мэдээллийн агуулгыг зохистойгоор цаг тутам шинэчлэх, олон нийтийн зарлал цацах техник тоног төхөөрөмж байрлуулах зэрэг төрөл бүрийн олон нийтийн хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслээр иргэдийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээнд зориулсан байна. Үүнээс гадна, хамтран ажиллаж буй орон нутгийн захиргаанууд багийн засаг дарга болон хорооны дарга нарын мэдээлэл түгээх чиг үүрэгт онцгой ач холбогдол өгсөн байна. Төгсгөлийн судалгаа эдгээр арга хэмжээний ашигт ажиллагааны үр дүнг танилцуулна.

Зураг 7 Мэдээллийн голлох таван эх сурвалж зорилтот болон хяналтын бүлгээр – давтан судалгааны үр дүнгээр⁷



N=743

Иргэдийн хууль тогтоомж, орон нутгийн захиргааны чиг үүрэг болон үйл ажиллагааны талаар мэдээлэл авдаг гол эх сурвалж нь телевиз байгаа нь суурь судалгааны үр дүнтэй нийцэж байгааг Зураг 7 харуулж байна. Суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад телевизээр мэдээлэл авдаг оролцогчдын тоо 7 хувиар өссөн байна (зорилтот болон хяналтын талбаруудыг нэгтгэн үзэхэд). Хяналтын талбар дахь иргэдийн мэдээлэл авдаг хоёр дахь түгээмэл эх сурвалж олон нийтийн хурал цуглаан дээр төрийн албан хаагчаас байгаа нь мөн суурь судалгааны үр дүнтэй нийцэж байна. Харин зорилтот талбар дахь хоёр дахь түгээмэл эх сурвалжаар ам дамжсан яриа сонгогдсон нь хяналтын талбараас ялгаатай байна. Үүнээс гадна орон нутгийн захиргааны мэдээллийн самбараас мэдээлэл авдаг оролцогчдын тоо суурь судалгааны 8 хувиас төгсгөлийн судалгаанд 12 хувь болж өссөн байна (зорилтот болон хяналтын талбаруудыг нэгтгэн үзэхэд).


⁶ ОНТИОН төслөөс өмнө орон нутгийн захиргаа мэдээллийн самбарыг зөвхөн захиргааны байрны үүдэнд байрлуулдаг байсан бөгөөд мэдээллийн самбартай танилцах хүсэлтэй иргэд засаг даргын байранд орох ёстой байв. Бага хэмжээний мөнгөн тусламжийг багийн төв, дэлгүүр, сургууль, олон нийтийн төв зэрэг иргэдийн төвлөрөл ихтэй газруудад нэмэлт мэдээллийн самбар байрлуулахад зориулсан байна.

⁷ Давтан судалгааны нэгтгэсэн дүн, зорилтот болон хяналтын бүлгээр.

Оролцогчдын хүйс, нас, орлогын түвшин, газарзүйн байршил болон мэдээллийн эх сурвалжуудын хооронд мэдэгдэхүйц харилцан хамаарал илрээгүй байна.

Ерөнхийдөө төгсгөлийн судалгаанд хамрагдсан зорилтот талбар дахь оролцогчдын нэрлэсэн орон нутгийн захиргааны мэдээлэл авах эх сурвалжийн тоо нэмэгдсэн бол хяналтын талбар дахь оролцогчдын нэрлэсэн эх сурвалжийн тоо эсрэгээр буурсан байна. 3 болон түүнээс дээш эх сурвалжаас мэдээлэл авсан оролцогчдын тоо зорилтот талбарын хувьд суурь судалгааны 7 хувиас давтан судалгаагаар 28 хувь болж өссөн байна. Үүний зэрэгцээ, мэдээлэлгүй буюу мэдээлэл авдаггүй оролцогчдын тоо зорилтот талбарын хувьд суурь судалгааны 13 хувиас 10 хувь болж буурсан байна. Харин эсрэгээр, хяналтын талбар дахь мэдээлэл авдаггүй оролцогчдын тоо 9.4 хувиас 16 хувь болж нэмэгдсэн байна. Эдгээр үр дүн нь ОНТИОН төслийн хүрээнд мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх орон нутгийн захиргааны арга хэмжээг иргэд үхамсарлаж мэдээлэл авах шинэ эх сурвалжуудыг ашиглаж эхэлж байгааг харуулж байна.

Зураг 8 Иргэдийн мэдээлэл авдаг эх сурвалжийн тооны өөрчлөлт хувиар




Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Орон нутгийн захиргааны мэдээлэл түгээлтийн ил тод байдлын талаар иргэдийн үзэл

Орон нутгийн захиргааны ил тод байдлын талаар үзэлд эерэг өөрчлөлт гарсан байна. Орон нутгийн захиргаа үйл ажиллагаагаа олон нийтэд тайлагнадаг гэсэн үзэлтэй оролцогчдын тоо зорилтот болон хяналтын бүлгийн хувьд ойролцоогоор 10 хувиар өссөн байгааг Зураг 9 харуулж байна. Хүйс, боловсролын түвшин, орлогын түвшин, ажил эрхлэлтийн байдал болон орон нутгийн захиргаа үйл ажиллагаагаа тайлагнах талаар үзлийн хооронд мэдэгдэхүйц харилцан хамаарал илрээгүй байна.

Зураг 9 Орон нутгийн засаглалын байгууллагууд нь өөрсдийн үйл ажиллагаа, төсвийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийг тайлагнадаг эсэх талаарх иргэдийн үнэлгээ




Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Санхүүгийн мэдээллийн тайлагналын ил тод байдлын хувьд суурь судалгаагаар зорилтот бүлгийн оролцогчдын үзэл хяналтын бүлгийн оролцогчдын үзлээс илүү эерэг байсан байна (зорилтот бүлгийн оролцогчдын 36 хувь төсвийн төлөвлөгөө болон зарцуулалтаа тайлагнадаг гэсэн бол хяналтын бүлгийн хувьд энэ үзүүлэлт 21 хувь байна). Иргэдийн ерөнхий ойлголт мэдлэгийн судалгааны үр дүнтэй адил, хяналтын талбарын оролцогчдын санхүүгийн мэдээллийн ил тод байдлын талаарх үзэл сайжирч зорилтот бүлгийн хэмжээнд хүрсэн бөгөөд ойролцоогоор 43 хувь болсон байна. Зорилтот талбарт иргэдийн үзэл 8 хувиар л сайжирсан байна. Хяналт болон зорилтот бүлгийн судалгааны үр дүн нийцэж байгаа нь ОНТИОН төсөл гэхээс илүү төв засгийн газраас Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн талаар ойлголт мэдлэгийн түвшин нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дагавар байж болзошгүй юм.⁸

Суурь судалгаанд хамрагдсан оролцогчдын орон нутгийн захиргааны үйл ажиллагааны тайлагналын үзэл болон газарзүйн байршлын хооронд мэдэгдэхүйц харилцан хамаарал илэрсэн. Сумын төвийн оролцогчдын орон нутгийн захиргааны тайлагналын талаарх үзэл Улаанбаатар хотын оролцогчдын үзлээс илүү эерэг байсан байна. Зорилтот болон хяналтын талбарт энэхүү харилцан хамаарал илэрсэнийг Зураг 10 харуулж байна.

⁸ 2014 онд Сангийн Яам бүх орон нутгийн захиргаанд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг дагаж мөрдөх шаардлага бүхий зааварчилгаа тараасан. Үүнээс гадна 2014 онд Монгол улс засгийн газрын санхүү төсвийн мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй болгох зорилготой Шилэн дансны тухай хууль шинээр баталсан.

Зураг 10 Орон нутгийн захиргаа өөрсдийн үйл ажиллагааг тайлагнадаг гэж үзсэн иргэдийн хувь, газар зүйн байршлаар




Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Давтан судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн оролцогчдын хувьд харин орон нутгийн захиргааны үйл ажиллагааны тайлагналын талаар эерэг үзэл болон газарзүйн байршлын хооронд харилцан хамаарал илэрсэнгүй. Хяналтын бүлгийн харилцан хамаарлын түвшин өөрчлөгдөөгүй хэвээрээ байна. Энэ нь Улаанбаатар хотын зорилтот талбар дахь үзүүлэлт харьцангуй сайжирсантай холбоотой юм. Улаанбаатар хотын түвшинд үйл ажиллагааны ил тод байдлын талаар иргэдийн эерэг үзэл 22 хувиас 63 хувь хүртэл өссөн байна. Оролцогчдын хүйс, орлогын түвшин, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал болон үйл ажиллагааны ил тод байдлын талаар үзлийн хооронд мэдэгдэхүйц харилцан хамаарал илэрсэнгүй.

Улаанбаатар хот дахь санхүүгийн мэдээллийн тайлагналын талаар иргэдийн үзэл мөн сайжирсан бол хяналтын талбаруудаас Говь-Угтаал сумын төвийн иргэдийн үзэл эрс сайжирсан байна. Үүний үр дүнд хяналтын талбарт илэрсэн хэвээр буй ил тод байдлын талаарх иргэдийн үзэл болон газарзүйн байршлын хоорондын харилцан хамаарал зорилтот талбарт хүчингүй болж байгааг Зураг 11 харуулж байна.


Зураг 11 Орон нутгийн захиргаа өөрсдийн төсвийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийг тайлагнадаг гэж үзсэн иргэдийн хувь, газар зүйн байршлаар



Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Үүнээс гадна төгсгөлийн судалгаанд суурь судалгаанд багтсан асуултуудаас гадна ОНТИОН төслийн явцад ил тод байдалд гарсан өөрчлөлтийн талаарх иргэдийн үзлийг оролцогчдоос тодорхойлох асуулт нэмэгдсэн. Оролцогчдын хагас орчим нь сайжралт гарсан гэж хариулсан энэхүү асуултын үр дүнг Зураг 12 харуулж байна.

Зураг 12 Сүүлийн нэг жилийн хугацаанд орон нутгийн захиргааны мэдээлэл тархаах талаар гаргасан чармайлт нэмэгдсэн эсэх талаар иргэдийн үнэлгээ, хувиар



N = 369


2. Иргэдийн оролцооны түвшинд гарсан өөрчлөлтүүд

ОНТИОН төслийн үндсэн зорилго нь орон нутгийн захиргааны шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино. Орон нутгийн захиргаанд иргэдийн судалгаа хийж, олон нийтийн хурал уулзалт зохион байгуулж (үүнд жил тутмын Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг тодорхойлох багтсан), хурал уулзалтын танхимыг тоног төхөөрөмжөөр хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хурал уулзалтын талаар олон нийтэд зарлах зэрэг арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор бага хэмжээний тусламжийн сан олгож дэмжсэн. Жишиг сум болгонд олон нийтийн хурал уулзалт зохион байгуулах ажилд туслах, хурал уулзалтын танхимыг хариуцах үүрэг бүхий Орон нутгийн зохицуулагч томилсон байна. Иргэдэд төрийн бодлого болон хөтөлбөрүүдийн талаар олон нийтийн санал бодолд нөлөөлөх, иргэд болон орон нутгийн захиргааны албан хаагчдад мэргэжлийн дэмжлэгийн үр чадвар олгох сургалтуудыг зохион байгуулсан байна.

Орон нутгийн захиргаатай уулзах боломжуудын ойлголт мэдлэг

Судалгаанд хамрагдсан оролцогчдоос орон нутгийн захиргааны албан хаагчидтай уулзах боломж олгодог ямар олон нийтийн уулзалтууд байдаг талаар тодруулсаныг зураг 13 харуулж байна.


Зураг 13 Олон нийтийн уулзалт/ хурал цуглааны талаарх иргэдийн мэдлэг – Звөхөн зорилтот бүлэг



Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Зорилтот талбар дахь иргэдийн орон нутгийн захиргааны албан хаагчидтай уулзах боломж олгодог олон нийтийн уулзалтуудын талаар ойлголт мэдлэг нэмэгдэж, “мэдэхгүй” гэж хариулсан оролцогчдын тоо 5 хувь болтол буурсан байна. Харин хяналтын талбарт “мэдэхгүй” гэж хариулсан оролцогчдын тоо 10 хувиар өсч 28 хувиас 39 хувь болсоныг Зураг 13 харуулж байна.

Зураг 14 Олон нийтийн уулзалт/ хурал цуглааны талаарх иргэдийн мэдлэг – Звөхөн хяналтын бүлэг




Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Зорилтот бүлгийн оролцогчдын хувьд Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хэлэлцүүлэг, Нээлттэй хаалганы өдөр болон дараагаар Засгийн газрын албан ёсны айлчлалын талаар ойлголт мэдлэг нэмэгдсэн байна. Бусад олон нийтийн уулзалтуудын хувьд ойлголт мэдлэгийн түвшин харьцангуй хэвээр үлдсэн буюу бага зэрэг бүүрсан байна. Харин хяналтын бүлгийн оролцогчдын хувьд сум дүүргийн иргэдийн хурал уулзалт, Засаг даргын уулзалт болон тухайн асуудал хариуцсан газар хэлтсийн албан хаагчдын уулзалтын талаар ойлголт мэдлэгийн түвшин өссөн байна. Эдгээр өөрчлөлтийг тайлбарлах шалтгаан судалгааны мэдээлэлд байхгүй байна.

Хяналтын бүлгийн оролцогчдын орон нутгийн захиргаатай уулзах боломжуудын ойлголт мэдлэгийн түвшин суурь судалгааны үзүүлэлтээс бүүрсан хэдий ч ойлголт мэдлэгийн агуулга болон чанар төгсгөлийн судалгаанд дээшилсэнийг Зураг 15 харуулж байна.

Зураг 15 Иргэд төрийн албан хаагчидтай уулзах боломж олгодог мэддэг олон нийтийн уулзалтын тоо




Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Хяналтын бүлгийн хувьд 3 болон түүнээс дээш олон нийтийн уулзалт нэрлэж чадах оролцогчдын тоо суурь судалгааны үзүүлэлттэй харьцуулахад дөрөв дахин өссөн байна. Зорилтот бүлгийн хувьд нэрлэж чадах орон нутгийн захиргааны албан хаагчидтай уулзах боломжуудын тоо мөн өссөн бөгөөд, 2 болон түүнээс дээш олон нийтийн уулзалт нэрлэж чадсан оролцогчдын тоо 18 хувиас 30 хувь хүрч бараг хоёр дахин өссөн байна. Хяналтын бүлгийн оролцогчдын дунд олон нийтийн уулзалтуудын талаар огт мэдлэггүй иргэдийн тоо илүү байгаа хэдий ч мэдлэгийн агуулга чанар мэдэгдэхүйц өссөн шалтгаан тодорхойгүй байна.

Орон нутгийн захиргаа болон иргэдийн хурал уулзалтын ирц

Судалгаанд хамрагдсан оролцогчдоос сүүлийн нэг жилийн хугацаанд баг болон хорооны иргэдийн хуралд оролцсон эсэхийг асуусан байна. Эдгээр хурал уулзалтууд улирал болгон зохион байгуулагддаг бөгөөд хурлыг хүчинтэй болгох иргэдийн тодорхой тоо заасан байдаг. Зураг 16 энэ асуултын үр дүнг харуулж байна.

Зураг 16 Сүүлийн 12 сард баг/хорооны иргэдийн хуралд оролцсон иргэдийн тоо




Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Баг болон хорооны иргэдийн хурлын ирц зорилтот (суурь судалгааны үзүүлэлтээс 14 хувь илүү) болон хяналтын (суурь судалгааны үзүүлэлтээс 17 хувь илүү) талбаруудад нэмэгдсэн бөгөөд хяналтын талбарын үзүүлэлт үл ялиг илүү өссөн байна.

Зорилтот болон хяналтын бүлгийн үр дүн ижил байгаа нь Сангийн яамны захирамжийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хэлэлцүүлгийн ирцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дагавар байж болзошгүй юм. Тэгсэн хэдий ч үүнийг батлах тодорхой мэдээлэл байхгүй байна. Ирцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан хэдий ч оролцогчдын хагасаас бага хувь хуралд оролцсоныг онцлох нь зүйтэй байх. Оролцогчдын хүйс, ажил эрхлэлтийн байдал, боловсролын түвшин, газарзүйн байршил ба баг болон хорооны иргэдийн хурлын ирцийн хооронд статистикийн хувьд мэдэгдэхүйц харилцан хамаарал илэрсэнгүй.

Зураг 17 Улаанбаатар хот дахь хоёр талбарын (хяналтын талбар болох Сүхбаатар дүүрэг болон зорилтот талбар болох Хан-Уул дүүрэг) ирцийн үзүүлэлтийг харуулж байна.

Зураг 17 Сүүлийн 12 сард баг/хорооны иргэдийн хуралд оролцсон Улаанбаатараас судалгаанд оролцогчдын тоо




Суурь судалгаа N=180;

Давтан судалгаа N=199

Ирцийн үзүүлэлтийг дэлгэрэнгүй задалж үзсэнээр судалгааны үр дүнг нэгтгэх нь Улаанбаатар хот дахь туршилтын талбар дахь иргэдийн ирцийн томоохон өсөлтийг далдлах аюултайг харуулж байна. Тус туршилтын талбар дахь хорооны иргэдийн хурлын ирц хяналтын талбарын үзүүлэлтээс бараг хоёр дахин өссөн байна.

Судалгаанд хамрагдсан оролцогчдоос сүүлийн нэг жилийн хугацаанд баг болон хорооны иргэдийн хуралд оролцоогүй шалтгааныг асуусан байна. Зураг 18 энэ асуултын үр дүнг харуулж байна.

Зураг 18 Баг/хорооны иргэдийн хуралд оролцоогүй шалтгаан- зөвхөн Давтан судалгаа




N= 425

Суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад сонирхоогүй учраас хуралд оролцоогүй иргэдийн тоо эрс буурсан байна. Зорилтот талбар дахь энэ үзүүлэлт суурь судалгааны 30 хувиас (хуралд оролцох завгүй гэсэн шалтгааны дараах хамгийн түгээмэл хариулт) төгсгөлийн судалгаанд 15 хувь болтол буурсан байна. Энэхүү үзүүлэлт хяналтын бүлгийн хувьд мөн буурсан ч өөрчлөлт нь арай бага байсан байна (10 хувиар буурсан). Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хэлэлцүүлэг иргэдийн хурал уулзалтанд оролцох сонирхолыг нэмэгдүүлсэн байж болзошгүй.

Хурал уулзалтанд оролцоогүй хамгийн түгээмэл шалтгаан нь оролцох цаг завгүй гэж хариулсан нь суурь судалгааны үр дүнтэй нийцэж байгаа бөгөөд зорилтот талбар дахь хамгийн түгээмэл шалтгаан хэвээр байна. Хурал уулзалт хэзээ зохион байгуулагдах талаар мэдээлэл олж аваагүй гэж хариулсан оролцогчдын тооны хувьд зорилтот болон хяналтын бүлгийн хооронд том ялгаа байна. Суурь судалгаанд мэдээлэл олж аваагүй оролцогчдын тоо зорилтот болон хяналтын бүлгийн хувьд ойролцоо байсан бол (зорилтот 22 хувь ба хяналт 20 хувь) төгсгөлийн судалгаанд зорилтот бүлгийн үзүүлэлт эрс сайжирсан байна. Энэ зорилтот бүлгийн иргэд баг болон хорооны иргэдийн хуралд оролцох сонирхолтой байгаагаас гадна хурал уулзалт хэзээ зохион байгуулагдах талаар илүү мэдээлэл авч байгааг харуулж байна.

Зураг 19 баг болон хорооны иргэдийн хурлын талаар мэдээлэл авсан эх сурвалжийн өөрчлөлтийг харуулж байна.

Зураг 19 Баг/хорооны иргэдийн хурлын талаарх мэдээллийн голлох 5 эх сурвалж




Суурь судалгаа N=259; Давтан судалгаа N=318

2014 онд баг болон хорооны иргэдийн хуралд оролцсон 5 хүн болгоны 2 нь (зорилтот болон хяналтын талбарын хувьд дунджаар 42.5 хувь) төрийн албан хаагчийн урилгаар ирсэнийг давтан судалгааны үр дүн харуулж байна. Түүний дараах хамгийн түгээмэл мэдээллийн эх сурвалжаар хэсгийн төлөөлөгч болон сайн дурын ажилтнууд шалгарсан байна. Энэ эх сурвалжийн үзүүлэлт ялангуяа зорилтот бүлгийн хувьд эрс өссөн байна. Орон нутгийн захиргааны мэдээллийн самбарын ач холбогдол багасч, суурь судалгааны үзүүлэлтээс 8.4 хувиар буурсан байна. Үүнтэй адил, өөрийн биеэр мэдээлэл олж авсан оролцогчдын тоо мөн багасч бараг хоёр дахин буурсан байна. Эдгээр судалгааны үр дүн баг болон хорооны иргэдийн хурлын ирцийг нэмэгдүүлэх орон нутгийн захиргааны арга хэмжээ сайжирсаныг харуулж байна. Судалгаанд оролцогчдын хүйс, орлогын түвшин, боловсролын түвшин, газарзүйн байрлал ба мэдээллийн эх сурвалжуудын хооронд мэдэгдэхүйц харилцан хамаарал илэрсэнгүй.

Орон нутгийн захиргаа болон иргэдийн хурал уулзалтын чанарын талаарх үзэл Баг болон хорооны иргэдийн хуралд оролцсон судалгаанд хамрагдсан оролцогчдын тоо өссөн хэдий ч хурал дээр санал хэлсэн оролцогчдын тоо буурсаныг Зураг 20 харуулж байна.

Зураг 20 Хурал дээр саналаа хэлсэн иргэдийн тоо



Суурь судалгаа N=257; Давтан судалгаа N=318

Энэхүү үзүүлэлт буурах болсон шалтгааныг тайлбарлах мэдээлэл асуумжид байсангүй. Суурь судалгаанд эмэгтэй оролцогчид эрэгтэй оролцогчдоос илүү санал хэлдэг үр дүн гарсан бол төгсгөлийн судалгааны үр дүнд хүйсийн ялгаа илэрсэнгүй.

Хурлын үеэр санал хэлсэн оролцогчдоос тухайн саналыг авч хэлэлцсэн эсэхийг асуусан бөгөөд Зураг 21 энэ асуултын үр дүнг харуулж байна.

Зураг 21 Хурлын үеэр саналыг нь авч хэлэлцсэн оролцогчдын тоо




Суурь судалгаа N=257; Давтан судалгаа N=318

Хурлын үеэр хэлсэн саналыг авч хэлэлцсэн үзүүлэлт хяналтын бүлгийн хувьд мэдэгдэхүйц нэмэгдэж 20 хувиар өссөн бол зорилтот бүлгийн хувьд бараг 11 хувиар буурсан байна. Говь-Угтаал сумын оролцогчдын хариулт хяналтын бүлгийн үзүүлэлтийг өсгөсөн бол Сүхбаатар дүүргийн оролцогчдын хувьд энэ үзүүлэлтэнд өөрчлөлт орсонгүй. Судалгаанд оролцогчдын хүйс, боловсролын түвшин, газарзүйн байршил ба хурлын үеэр хэлсэн саналыг авч хэлэлцсэн үзүүлэлтийн хооронд мэдэгдэхүйц харилцан хамаарал илэрсэнгүй.

Хурлын үйл ажиллагааны сэтгэл ханамж хоёр бүлгийн хувьд сайжирсаныг Зураг 22 харуулж байна.

Зураг 22 Оролцсон хурлын талаарх иргэдийн сэтгэл ханамж




Суурь судалгаа N=257; Давтан судалгаа N=318

Баг болон хорооны иргэдийн хурлын үйл ажиллагаанд сэтгэл маш ханамжтай болон зарим талаар ханамжтай гэж хариулсан оролцогчдын тоо зорилтот бүлгийн хувьд 50 хувиас 60 хувь болтол өссөн байна. Хяналтын бүлгийн хувьд сэтгэл ханамжийн түвшин үүнээс илүү сайжирч, оролцогчдын хагас нь сэтгэл маш ханамжтай гэсэн хариулт өгсөн байна. Говь-Угтаал сумын оролцогчдын хариулт хяналтын бүлгийн үзүүлэлтийг өсгөсөн бол Сүхбаатар дүүргийн оролцогчдын хувьд энэ үзүүлэлтэнд өөрчлөлт орсонгүй.

Олон нийтийн хурал уулзалтанд оролцсон иргэдээс хурлын үр ашгийг дээшлүүлэх арга замуудын талаар асуусан бөгөөд Зураг 23 энэ асуултын үр дүнг харуулж байна.

Зураг 23 Иргэдийн хурлыг сайжруулах арга замууд



N= 318


Хурлын үр ашгийг дээшлүүлэх хамгийн түгээмэл арга замаар “хурлын зарыг илүү хүртээмжтэй болгох” гэсэн хариулт шалгарсан нь суурь судалгааны үр дүнтэй нийцэж байна.

Баг болон хорооны иргэдийн хуралд оролцсон төгсгөлийн судалгаанд хамрагдсан оролцогчдын бараг хагас нь (нийт оролцогчдын 45.3 хувь) хурлын цагийг хурал зохион байгуулагдахаас өмнө зарлаж, хангалттай хугацаа өгөх нь зүйтэй гэж үзсэн байна.

Зорилтот болон хяналтын талбар дахь иргэд хурал уулзалтын чанарыг дээшлүүлж, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх хүсэлтэй байна. Жишээ нь “иргэдэд санал бодлоо илэрхийлэхэд хангалттай хугацаа өгөх” гэсэн хариулт өгсөн оролцогчдын тоо суурь судалгааны үзүүлэлтээс 11.9 хувиар өссөн байна. Шийдвэр гаргагч болон холбогдох асуултанд албан ёсны хариу өгөх албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх сонирхолтой оролцогчдын тоо мөн өссөн байна. Эдгээр хурлын үр ашгийг дээшлүүлэх арга замууд зорилтот болон хяналтын талбар дахь хамгийн түгээмэл сонголтууд байна.

Олон нийтийн хурал уулзалтанд оролцсон иргэдээс тухайн хурлын үр дүн болон эцсийн шийдвэрийн талаар мэдээлэл авсан эсэхийг мөн асуусан байна. Хурлын шийдвэрийн талаар мэдээлэл авах нь иргэдийн цаашдын оролцоог дэмжиж, иргэдийн хувьд хурлын ач холбогдлыг өсгөхөд чухал юм. Зураг 24 энэ асуултын үр дүнг харуулж байна.

Зураг 24 Хурлын эцсийн шийдвэрийг олж мэдсэн оролцогчдын тоо



Суурь судалгаа N=257; Давтан судалгаа N=318

Судалгааны үр дүнгээс харахад хурлын шийдвэрийн талаар иргэдэд мэдээлэх арга хэмжээ хяналтын талбарт эрс сайжирсан бөгөөд харин зорилтот талбарт өөрчлөлт ороогүй байна. Хяналтын талбарт хурлын үр дүн болон эцсийн шийдвэрийн талаар мэдээлэл авсан оролцогчдын тоо хоёр гаран дахин нэмэгдсэн байна. Говь-Угтаал сумын үзүүлэлт хяналтын талбарын нэгдсэн үзүүлэлтийг дээш нь татсан хэдий ч Улаанбаатар хот дахь хяналтын талбаруудад өсөлт гараагүйг Хүснэгт 5 харуулж байна.


Хүснэгт 3 Хурлын эцсийн шийдвэрийн талаар олж мэдсэн оролцогчдын тоо, газарзүйн байршлаар

Газар зүйн байршил	Зорилтот бүлэг		Хяналтын бүлэг	
	Суурь судалгаа N=93	Давтан судалгаа N=105	Суурь судалгаа N=11	Давтан судалгаа N=44
Улаанбаатар	1 9.1%	19 48.7%	1 11.1%	2 10.0%
Аймгийн төв	16 23.5%	31 45.6%	N/A --	N/A --
Сумын төв	76 54.3%	55 44.0%	10 26.3%	42 63.6%
Нийт	93 42.5%	105 45.3%	11 23.4%	44 51.2%

Орон нутгийн захиргааны мэдээлэл түгээлтийн талаар хийсэн судалгааны үр дүнтэй адил Улаанбаатар хот дахь зорилтот талбар болон аймгийн төвүүд дэх хурлын үр дүн болон эцсийн шийдвэрийн талаар иргэдэд мэдээлэх үзүүлэлт суурь судалгааны үзүүлэлтээс мэдэгдэхүйц сайжирсан бөгөөд сумын төвийн зорилтот талбаруудын үзүүлэлтээс өндөр байна. Харин хяналтын талбарын хувьд сумын төвийн үзүүлэлт сайжирсан бол Улаанбаатар хот дахь талбарын үзүүлэлт өөрчлөгдөөгүй байна.

Иргэдийн ерөнхий итгэл болон оролцооны түвшнийг тодорхойлох зорилгоор судалгаанд хамрагдсан оролцогчдоос олон нийтийн хурал уулзалтын оролцоо болон ач холбогдлын талаар санал нийлж байгаа эсэхийг асуусан цуврал асуулт асуусан байна. Эдгээр асуултуудын үр дүнг Зураг 25 харуулж байна.

Зураг 25 Иргэдийн хурлын оролцоо болон төлөөллийн талаарх оролцогчдын үнэлгээ




Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Зорилтот бүлгийн оролцогчдын хувьд “манай орон нутгийн иргэдийн хурал дээр хүн бүр өөрийн үзэл бодлоо илэрхийлж чаддаг” болон “манай орон нутгийн иргэдийн хурал хүмүүсий хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулдаг” гэдэг үзэл хамгийн ихээр нэмэгдэж бараг 8 хувиар өссөн байна. Харин “манай орон нутгийн захиргаа иргэдийн оролцоог дэмждэг” гэж хариулсан оролцогчдын тоо 5 хувиар өссөн байна. Хяналтын бүлгийн үзүүлэлт үүнээс илүү өссөн нь мөн л Говь-Угтаал сумын үзүүлэлтэнд эерэг өөрчлөлт орсонтой холбоотой. Судалгаанд хамрагдсан оролцогчдын хүйс, нас, боловсролын түвшин, орлогын түвшин, ажил эрхэлсэн байдал болон эдгээр асуултын хариултуудын хооронд мэдэгдэхүйц харилцан хамаарал илэрсэнгүй. Сайжралт ажиглагдсан хэдий ч нийт иргэдийн зөвхөн хасаг орчим нь эерэг хариулт өгч байгааг орон нутгийн төрийн албан хаагчид анхааралдаа авч, энэ тал дээр цаашдын арга хэмжээ авах нь зүйтэй.

Иргэдийн оролцоог нэмэгдүүлсэнээр шийдэх асуудлууд

Судалгаанд хамрагдсан оролцогчдоос орон нутгийн захиргаа иргэдийн оролцоотойгоор шийдвэл зохистой асуудлын талаар тодруулсан байна. Энэ асуулт нь юуны өмнө төслийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааг төлөвлөхөд зориулагдсан хэдий ч орон нутгийн захиргааны цаашдын үйл ажиллагаанд мөн хамааралтай юм. Зураг 26 энэ асуултын үр дүнг харуулж байна.

Зураг 26 Шийдвэр гаргахдаа иргэдийг оролцуулах шаардлагатай асуудлууд



Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743


Судалгаанд хамрагдсан оролцогчдын үзэж байгаагаар орон нутгийн захиргаанаас иргэдийн оролцоотойгоор шийдэх хамгийн чухал гурван асуудал:

1. **Эдийн засгийн өсөлт болон шинэ ажлын байр/ажилгүйдэл** – Нийт оролцогчдын 28 хувь үүнийг хамгийн чухал асуудал гэж үзэж байгаа нь суурь судалгааны үр дүнтэй нийцэж байна. Аймгийн төвийн оролцогчдын 37 хувь сонгосон бол (аймгийн төвийн хувьд хамгийн түгээмэл сонголт), энэ үзүүлэлт сумын төвд 30 хувь (31 хувийн үзүүлэлт бүхий байгаль орчны бохирдлын дараах асуудал) харин Улаанбаатар хотод 17 хувь байна.
2. **Газар төлөвлөлт/хуваарилалт** - Нийт оролцогчдын 27 хувь үүнийг хамгийн чухал асуудал гэж үзэж байна (суурь судалгааны үзүүлэлтээс ойролцоогоор 8 хувиар өссөн). Аймгийн төвийн оролцогчдын хагас орчим (44 хувь) нь газар төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор шийдэх асуудлаар сонгосон байна. Улаанбаатар хотын хувьд газар төлөвлөлт нь хамгийн чухал асуудал болсон бөгөөд нийт оролцогчдын 24 хувь сонгосон байна. Сумын төвд газар төлөвлөлтийг нийт оролцогчдын 20 хувь сонгосон байна.
3. **Байгаль орчны бохирдол** – Нийт оролцогчдын 24 хувь сонгосон бөгөөд гурав дахь хамгийн чухал асуудал юм (суурь судалгааны үзүүлэлтээс 7 хувиар буурсан). Байгаль орчны бохирдлыг хамгийн чухал гэж үзсэн оролцогчдын гуравны хоёр нь (179 оролцогчдын 109) сумын төвийн иргэд байсан бөгөөд сумын төвийн хувьд хамгийн чухал асуудлаар сонгогдсон байна (сумын төвийн оролцогчдын 31 хувь сонгосон). Аймгийн төвд байгаль орчны бохирдлын асуудлыг 24 хувь сонгосон бол Улаанбаатар хотын оролцогчдын дөнгөж 12 хувь л чухал асуудлаар сонгосон байна.

Иргэдийн оролцоонд тулгарах бэрхшээлүүд

Судалгаанд хамрагдсан бүх талбарын оролцогчдоос иргэдийн оролцоонд ямар бэрхшээлүүд тулгардаг талаар асуусан байна. Зураг 27 энэ асуултын үр дүнг харуулж байна.

Зураг 27 Шийдвэр гаргах үйл явцад шууд оролцоход гардаг бэрхшээлүүд



N=743

Оролцогчдын үзэж байгаагаар иргэдийн оролцоонд тулгардаг хамгийн том бэрхшээл нь хэрхэн оролцох талаар ойлголт мэдлэг болон мэдээлэл байхгүй (44 хувь), тухайн хурлаар хэлэлцэх сэдвийн талаарх мэдээлэл дутмаг (36 хувь) болон хурлын талаарх мэдээлэл авдаггүй, хурал

хэзээ болохыг мэддэггүй (24 хувь) гэсэн байна. Суурь судалгаанд мөн эдгээр бэрхшээлүүд хамгийн түгээмэл байсан бөгөөд харин үзүүлэлтүүд нь өссөн байна:

- хэрхэн оролцох талаар ойлголт мэдлэг болон мэдээлэл байхгүй бэрхшээл 16 хувиар
- тухайн хурлаар хэлэлцэх сэдвийн талаарх мэдээлэл дутмаг бэрхшээл 5.6 хувиар
- хурлын талаарх мэдээлэл авдаггүй, хурал хэзээ болохыг мэддэггүй бэрхшээл 7 хувиар


Иргэдийн оролцоонд тулгарах бэрхшээлийн судалгааны үр дүн хурал уулзалт хэзээ зохион байгуулагдах талаар мэдээлэл олж аваагүйн улмаас оролцож чадаагүй хяналтын бүлгийн иргэдийн тоо зорилтот бүлгийн үзүүлэлтээс эрс их байна гэсэн үр дүнтэй зарим талаар зөрчилдөж байна.

3. Хөндлөн суралцах

ОНТИОН төслийн нэг зорилго нь түршилтын талбаруудын шийдвэр-гаргагч болон иргэдийг холбож, дадлага туршлага солилцох, бие биенээсээ суралцах боломж олгох юм. Энэхүү хөндлөн суралцах арга хэмжээнүүд ихэвчлэн орон нутгийн захиргааны албан хаагчдад чиглэсэн (жишээ нь сум болон хорооны засаг дарга болон хурлын тэргүүлэгч нар бүс нутаг болон үндэсний хэмжээний хэд хэдэн хуралдаан зөвлөгөөнд оролцсон байна). Цөөн тооны энгийн иргэд эдгээр арга хэмжээнд шууд хамрагдах юм. Хэдий тийм боловч олон нийтийн хэвлэл мэдээлийн хэрэгслийн кампанит ажлын зарим арга хэмжээ байгаль орчныг хамгаалах хөдөлгөөн, Орон нутгийн хөгжлийн санг ашиглах санхүүжилтын хүсэлт зэрэг Монгол дахь оролцооны дадлага туршлагын жишээг хамарсан байна.

Судалгааны хүрээнд ашигласан асуумж нь Монгол улсын бусад орон нутагт хэрэгжүүлсэн иргэдийн оролцооны ерөнхий түвшнийг нэмэгдүүлэх сайн туршлага, үлгэр жишээ дадлагын талаарх ойлголт мэдлэгтэй иргэдийн харьцааг тодорхойлох зорилготой байсан. Асуултууд бусад санаачлагын жишээ, тохиолдлуудын талаар ойлголт мэдлэгийн түвшин, хоёрт адил төстэй санаачлагыг хэрэгжүүлэх оролдлого байсан эсэхийг тодорхойлоход чиглэсэн байв. Суурь болон давтан судалгааны үр дүнг харьцуулахад Монгол улсын бусад орон нутагт хэрэгжүүлсэн сайн туршлага, үлгэр жишээ дадлагын талаарх ойлголт мэдлэгийн түвшин зорилтот болон хяналтын талбарт бага зэрэг л нэмэгдсэнийг Зураг 28 харуулж байна.

Зураг 28 Та аль нэг өөр орон нутагт иргэдийн оролцоог амжилттай хангаж буй тохиолдлыг мэдэх үү?



Суурь судалгаа N=725; Давтан судалгаа N=743

Бусад орон нутагт иргэдийн оролцоог амжилттай хангаж буй тохиолдлыг мэдэх судалгаанд хамрагсдан оролцогчдын дийлэнх нь мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийг хэрэгслээр авч байгааг Хүснэгт 6 харуулж байна. Олон нийтийн хэвлэл мэдээлийн хэрэгслүүд сумын төвийн оршин суугчдын хувьд хамаарал өндөртэй байна.

Хүснэгт 4 Бусад туршлагын талаар мэдээлэл авсан эх сурвалж⁹

Мэдээллийн эх сурвалж	Суурь судалгаа		Давтан судалгаа	
	Зорилтот	Хяналтын	Зорилтот	Хяналтын
Телевиз	63%	28%	45%	49%
Радио			4%	2%
Сонин	1%	0%	8%	17%
Сурталчилгааны хуудас/тараах материал	1%	4%	2%	12%
Зурагт хуудас			0%	17%
Интернэт	0%	4%	8%	2%
ТББ/ИНБ/төсөл хөтөлбөр			4%	2%
Ерөнхийлөгчийн Тамгын Газраас зохион байгуулдаг хурал, уулзалт	0%	4%	1%	0%
Баг/хорооны иргэдийн хурал			3%	0%
Бусад			51%	44%
Ам дамжсан яриа	13%	16%		
Өөрөө олж мэдсэн	21%	44%		
Нийт	100%	100%	100%	100%

Суурь судалгаа N=107; Давтан судалгаа N=142


Хамааралтай мэдээллийн эх сурвалжийн тоо суурь судалгаа хийгдсэнээс хойш бага зэрэг нэмэгдсэн байна. Жишээ нь оролцогчдын давтан судалгаанд нэрлэсэн төрөл бүрийн ТББ-ын төсөл болон хөтөлбөрийн сурталчилгааны хуудас, тараах материал ба орон нутгийн уулзалт зөвлөгөөн зэрэг мэдээллийн эх сурвалжийг суурь судалгаанд дурьдаагүй байна. Эдгээр жишээ нь ОНТИОН төслийн үр дүнд гарсан материал мөн эсэхийг судалгааны мэдээллээс тогтоох боломжгүй байна.

Бусад орон нутагт иргэдийн оролцоог амжилттай хангаж буй тохиолдлыг мэдэх судалгаанд хамрагдсан оролцогчдоос тухайн жишээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсан байна. Хамгийн түгээмэл жишээ нь аймаг болгонд хэрэгжүүлж буй “Жишиг сүм” хөтөлбөр болон үлс даяар хэрэгжүүлж буй хөдөө орон нутгийн орон сууцны төсөл байна. Орон нутгийн захиргаа болон төрийн үйлчилгээний албан хаагчид бусад санаачлагын талаар ойлголт мэдлэг илүү нь тогтоогдсон хэдий ч энэ үзүүлэлт нь статистикийн хувьд ач холбогдолгүй юм.

Бусад орон нутагт иргэдийн оролцоог амжилттай хангаж буй тохиолдлыг мэдэх судалгаанд хамрагдсан оролцогчдоос өөрсдийн орон нутагт адил төстэй санаачлага хэрэгжүүлэх оролдлого байсан эсэхийг асуусан байна. Энэ асуултанд эерэгээр хариулсан (тийм, ижил төстэй иргэдийн оролцоог дэмжих санаачлага манай орон нутагт хэрэгжүүлсэн талаар мэднэ) оролцогчдын тоо хэтэрхий цөөн (нийт оролцогчдын 4 хувь) байсан тул статистикийн хувьд ач холбогдол өгсөнгүй. Зураг 29 энэ асуултын үр дүнг харуулж байна.

⁹Асуулгад тухайн сонголт байгаагүй тохиолдолд харгалзах нүд хоосон байгаа.


Зураг 29 Хэн нэгэн танай орон нутагт дээрхтэй адил төстэй санаачлагыг хэрэгжүүлсэн үү?



Суурь судалгаанд нийт 109 хариултаас N=28 тийм гэж хариулсан ; Давтан судалгаанд нийт 142 хариултаас N=29 тийм гэж хариулсан

Түүнтэй адил бусад орон нутагт иргэдийн оролцоог амжилттай хангаж буй тохиолдлыг мэдэх судалгаанд хамрагдсан оролцогчдоос өөрсдийн орон нутагт адил төстэй санаачлага хэрэгжүүлэх оролдлого хийгээгүй талаар асуусан байна. Зураг 30 энэ асуултын үр дүнг харуулж байна.

Зураг 30 Бусад орон нутгийн туршлагыг хэрэгжүүлээгүй шалтгаан



Суурь судалгаа N=107; Давтан судалгаа N=142

Төгсгөлийн судалгаанд хамрагдсан оролцогчдын хамгийн түгээмэл хариулт нь “хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр байхгүй” байсан бөгөөд араас нь маш ойрхон “хэрхэн хэрэгжүүлэхийг мэдэхгүй” болон “орон нутгийн захиргаа хүлээж авахгүй” гэсэн хариултауд сонгогдсон байна. Энэ асуултын хувьд зорилтот болон хяналтын бүлгийн хооронд мэдэгдэхүйц ялгаа гарсангүй. Эдгээр хариултауд Монголд иргэдийн оролцооны санаачлага шинээр хэрэгжүүлэхэд гадны болон дотоодын доноруудаас авах санхүү болон техникийн дэмжлэгийн ач холбогдлыг онцолж байна.

4. Иргэдийн санал хүсэлт болон гомдол


ОНТИОН төслийн нэг зорилго нь төрийн албан хаагч болон иргэд хоорондын харилцаа холбоог сайжруулсанаар төрийн үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх юм. Энэхүү харилцаа холбоог дэмжих арга хэмжээнд тодорхой төрийн үйлчилгээнд (нийтийн тээвэр эсвэл хатуу хог хаягдлын менежмент) чиглэсэн олон нийтийн хурал үүлзалтыг ивээн тэтгэх ажлууд багтсан.

Үүнээс гадна 2014 оны хоёрдугаар хагаст бүх талбарт нийгмийн хариуцлагын онооны хуудсыг нэвтрүүлсэн. Энэхүү онооны хуудас нь сумын нутаг дэвсгэр дэх гол төрийн үйлчилгээний (ихэвчлэн сургууль эсвэл эмнэлэг) сэтгэл ханамжийн түвшнийг хэмжих, боломжит сайжруулалт болон тулгамдсан асуудлуудыг тодорхойлох болон үйлчилгээ олгогч байгууллагуудын анхаарлыг шаардлагатай нутаг дэвсгэрт хандуулах зорилготой юм. Онооны хуудсыг төгсгөлийн судалгааны мэдээлэл цуглуулах явцад хэрэгжүүлсэн учраас онооны хуудсын үр нөлөө нь судалгааны үр дүнд илрэх боломжгүй юм. ОНТИОН төслийн хүрээнд Ховд аймгаас бусад орон нутагт гомдлын механизм дээр тусгайлан ажиллаагүй.

Иргэдийн гомдол

Судалгаанд хамрагдсан оролцогчдоос орон нутгийн захиргаанд хандан ямар нэг гомдол гаргасан үзүүлэлт зорилтот болон хяналтын бүлгийн хувьд суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад харьцангуй өөрчлөгдөөгүй (бага зэрэг бүүрсан) байгааг Зураг 31 харуулж байна.


Зураг 31 Сүүлийн 12 сард орон нутгийн захиргаанд өргөдөл, гомдол гаргасан иргэдийн тоо



Суурь судалгаа N=719; Давтан судалгаа N=741

Санал хүсэлт гаргаагүй шалтгааны хувьд мөн суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүйг Зураг 32 харуулж байна.


Зураг 32 Өргөдөл гомдол гаргаагүй шалтгаан



Суурь судалгаа N=566; Давтан судалгаа N=626

Орон нутгийн захиргаа иргэдийн санал гомдолд үндэслэн ямар нэг зүйл өөрчлөнө, хариу үйлдэл үзүүлнэ гэдэгт итгэхгүй оролцогчдын тоо зорилтот болон хяналтын бүлгийн хувьд бага зэрэг өссөн байна. Сүүлийн 12 сард орон нутгийн захиргаанд хандан ямар нэг санал хүсэлт, өргөдөл, гомдол гаргасан оролцогчдын хандсан арга замын судалгааг Зураг 32 харуулж байна.

Зураг 33 Өргөдөл гомдол гаргасан арга зам




Суурь судалгаа N=127; Давтан судалгаа N=116

Зорилтот болон хяналтын бүлгийн оролцогчдын дийлэнх нь бичгээр болон амаар буюу төрийн албан хаагчтай үулзаж санал хүсэлт гаргасан нь суурь судалгааны үр дүнтэй нийцэж байна. Давтан судалгааны үр дүнгээр харин и-мэйл болон утсаар санал хүсэлт гаргах тохиолдол

зорилтот бүлгийн хувьд нэмэгдсэн байна. Энэ нь орон нутгийн захиргааны байгууллага иргэдээс санал хүсэлт авах нээлттэй утас, и-мэйл хаяг ажиллуулж байгаатай холбоотой байж болох хэдий ч үүнийг судалгааны мэдээлэл дээр үндэслэн баталгаажуулах боломжгүй байна. Зорилтот бүлгийн оролцогчид суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад уулзахаас илүү бичгээр болон утсаар санал хүсэлтээ гаргахыг илүүд үздэг болсон байна. Иргэд хэнд хандаж санал хүсэлтээ гаргасан талаар хийсэн судалгааны үр дүн суурь судалгааны үр дүнтэй нийцэж байна.

Санал хүсэлт, гомдол гаргасан оролцогчдоос орон нутгийн захиргаа хариу өгсөн эсэхийг асуусан байна. Зураг 33 энэ асуултын үр дүнг харуулж байна.


Зураг 34 Танд орон нутгийн захиргаанаас хэд хоногийн дараа хариу өгсөн бэ?



Суурь судалгаа N=127; Давтан судалгаа N=116


Суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад зорилтот талбар дахь орон нутгийн захиргаа хариу өгөх тохиолдол буурсан байна. Зураг 34 энэ бүлгийн судалгааны үр дүнгийн хураангуй дүгнэлтийг харуулж байна.

Зураг 35 Санал, хүсэлт гаргаж буй хувь хэмжээ



Дөрвөн зорилтот талбарт төсөл хэрэгжиж эхэлсэнээс хойш өмнөх жилтэй харьцуулахад орон нутгийн захиргаа иргэдийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах хандлагад өөрчлөлт орсон эсэхийг асуусан байна. Энэ асуултын үр дүнг Зураг 35 харуулж байна.

Зураг 36 Өмнөх жилтэй харьцуулахад орон нутгийн удирдлагын иргэдийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах хандлагад өөрчлөлт орсон уу?




Эх сурвалж: Давтан судалгаа, зөвхөн 4 зорилтот талбараас, N= 369

Орон нутгийн захиргаа иргэдийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах хандлагад өөрчлөлт орсон эсэхийг асуухад зорилтот бүлгийн нийт оролцогчдын 42 хувь нь хандлага сайжирсан, 31 хувь өөрчлөгдөөгүй, харин 22.5 хувь мэдэхгүй гэж хариулсан байна. Оролцогчдын зөвхөн 4 хувь л хандлага муудсан гэж хариулсан байна.

Сүүлийн 12 сарын хугацаанд орон нутгийн захиргаанд санал хүсэлт, гомдол гаргасан оролцогчдын хувьд орон нутгийн захиргааны хандлагын үзүүлэлт дундажаас бага зэрэг доогуур гарсан байгааг Зураг 36 харуулж байна. Орон нутгийн захиргааны хандлага хамгийн ихээр сайжирсан үзүүлэлт Улаанбаатар хотод ажиглагдаж байна.

Зураг 37 Орон нутгийн захиргаанд өргөдөл гомдол гаргасан иргэдийн орон нутгийн хандлагын талаарх үнэлгээ




Эх сурвалж: Давтан судалгаа, зөвхөн 4 зорилтот талбараас, Сүүлийн 12 сард өргөдөл гомдол гаргасан иргэд. N= 244

Төрийн үйлчилгээний иргэдийн сэтгэл ханамж

Судалгаанд хамрагдсан оролцогчдоос орон нутгийн захиргаанаас хангаж буй гол төрийн үйлчилгээнүүдэд хэр сэтгэл ханамжтай байдаг талаар асуусан байна. Энэ асуултыг үр дүнг Зураг 37 харуулж байна.

Зураг 38 Төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн талаарх суурь болон давтан судалгааны үр дүн




Note: Data shows target and control site results aggregated. Суурь судалгаа N=725; Follow up survey N=741 Засвар үйлчилгээ ба төрийн бодлого болон хөтөлбөрүүдийн талаар олон нийтийн санал бодолд нөлөөлөх олон нийтийн дэмжлэгийн талаар асуултууд суурь судалгаанд ороогүй учраас харьцуулах үр дүн байхгүй.

Орон нутгийн зам, эмнэлэг, нийтийн аж ахуйн үйлчилгээ, болон байгаль хамгааллын талаар үзэл суурь судалгааны үзүүлэлттэй харьцуулахад бага зэрэг сайжирсан байна. Харин сургууль болон газар харилцааны чанарын талаарх үзэл бага зэрэг муудсан байна.

Зорилтот болон хяналтын талбар дахь төрийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамж, үзлийн ялгааг Зураг 38 харуулж байна.

Зураг 39 Иргэдийн төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн төвшин – Давтан судалгааны үр дүн зорилтот болон хяналтын бүлгээр



Source: Follow up survey N=741

Давтан судалгааны үр дүнг зорилтот болон хяналтын бүлгээр харьцуулахад, хяналтын бүлгийн орлоцогчдын эмнэлэгийн үйлчилгээний үнэлгээ илүү байсан бөгөөд бусад төрийн үйлчилгээний хувьд мэдэгдэхүйц ялгаа илрээгүй байна. Нөгөө талаар, хяналтын бүлгийн оролцогчид орон нутгийн зам, байгаль хамгаалал болон олон нийтийн газрын тохижилт, засварт “сэтгэл маш ханамжгүй” гэсэн үнэлгээ өгөх нь илүү байна.

Судалгаанд хамрагдсан оролцогчдоос орон нутгийн захиргаа төрийн үйлчилгээнүүдийг сайжруулахад тулгарч буй бэрхшээлүүдийн талаар асуусан байна. Оролцогчдын үзэж байгаагаар төрийн үйлчилгээг сайжруулахад тулгарч буй хамгийн том бэрхшээлүүд төсөв хүрэлцэхгүй, арга зүй дутмаг ба орон нутгийн захиргаа болон олон нийтийн хооронд ашиг сонирхол зөрчилддөг гэсэн байна. Суурь болон давтан судалгааны үр дүнд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаагүй байна.

БҮЛЭГ V. ОРОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэ бүлэг орон нутгийн төрийн албан хаагчидтай хийсэн хагас бүтэцчилсэн ярилцлагын үр дүнг хэлэлцэнэ. Давтан судалгааны үеэр арга хэмжээ авсан 6 талбарын 24 төрийн албан хаагчдаас ярилцлага авсан байна. Оролцогчдын дийлэнх нь засаг дарга, засаг даргын орлогч, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүд болон хурлын тэргүүлэгч нар байв. Эдгээр ярилцлагаас гадна Азийн Сан 9 өөр талбар дахь 14 засаг дарга болон хурлын тэргүүлэгч нараас ижил загварын дагуу хагас бүтэцчилсэн ярилцлага авсан байна. Доорх судалгааны үр дүнд эдгээр нэмэлт ярилцлагын мэдээлэл багтсан бөгөөд энэхүү дүн шинжилгээнд 17 туршилтын талбарын 16 талбар дахь нийт 38 төрийн албан хаагчдаас цуглуулсан мэдээлэл орсон болно.

Төсөл хэрэгжүүлэх явцад иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөрийн тоо төслийн логистик болон хүн амын хэмжээнээс болж хязгаарлагдсан тул шууд дэмжлэг туслалцааны үндсэн хэсэг орон нутгийн захиргааны төлөөлөгч нарт чиглэсэн юм. ОНТИОН төслийн хүрээнд орон нутгийн захиргаанд өгсөн дэмжлэгт тулгамдсан асуудлыг шийдэхэд зориулсан арга хэмжээг санхүүжүүлэх бага хэмжээний тусламжийн сан багтсан. Үүний зэрэгцээ, Азийн Сантай хамтран 6 жишиг сум оролцсон бөгөөд тухайн аймаг дахь хөтөлбөрийн хэрэгжилтэнд туслах Орон нутгийн зохицуулагч сонгосон байна. Орон нутгийн зохицуулагч нь ОНТИОН төслийн багийн ахлагчаас гадна засаг дарга эсвэл хурлын төлөөлөгчид өдөр тутмын тайлан танилцуулсан. Төслийн явцад хангасан хүний болон санхүүгийн нөөц орон нутгийн захиргаанд шууд хүрсэн юм.

Ярилцлага нь хагас бүтэцчилсэн буюу хагас нээлттэй асуумжийн хэлбэртэй байсан бөгөөд төслийн дөрвөн талыг үнэлсэн (Хавсралт 1 дэх асуумжтай танилцана уу)


- Хамаарал;
- Ашигт ажиллагаа;
- Бүтээмж; ба
- Тогтвортой хөгжил.

1. Хамаарал

Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үзэж байгаагаар ОНТИОН төслийн дэмжлэг орон нутгийн захиргааны хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулж чадсан гэдгийг Зураг 39 харуулж байна. Ерөнхийлөгчийн Тамгын газрын санаачлагууд болон Орон нутгийн хөгжлийн сангийн олон нийтийн хэлэлцүүлэг болон хэрэгжүүлэлт хамгийн чухал асуудлаар сонгогдсон байна.¹⁰

¹⁰ 2014 онд судалгаа хийхээс өмнө Ерөнхийлөгчийн Тамгын газраас энэ хоёр асуудлын талаар зөвлөмж бичиг орон нутгийн захиргаанд хүргэсэн байна.

Зураг 40 Төслийн үйл ажиллагааны орон нутгийн ашиг сонирхолтой хамааралтай байдал¹¹



ОНТИОН төслийн дэмжлэг болон үйл ажиллагаа орон нутгийн захиргааны хэрэгцээ шаардлагад хамааралтай бөгөөд төрийн албан хаагчдаас эерэг хариу авсан байна. Аль ч сэдвийн хувьд орон нутгийн захиргаанаас “сонирхохгүй байна” гэсэн хариу авсангүй.

Оролцогчдоос авсан чанарын шинжтэй саналууд иргэдэд мэдээлэл хүргэхэд төслийн дэмжлэг чухал ач холбогдолтой байсныг онцолсон байна. Энэ асуултанд санал бодлоо илэрхийлсэн оролцогчдын 38 хувь (24 оролцогчдын 9) ОНТИОН төслийн арга хэмжээний үр дүнд олон нийтийн хурал уулзалтын ирц болон иргэдийн идэвхи нэмэгдсэн гэж үзсэн байна.

Төслийн дэмжлэг болон арга хэмжээ орон нутгийн захиргааны хэрэгцээ шаардлагад нийцсэнийг илэрхийлсэн бусад чанарын шинжтэй саналууд:

- Ерөнхий бодлого, хууль тогтоомж болон бусад дүрэм журам – Төслийн үйл ажиллагаа хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газрын бодлого болон бусад дүрэм журмыг (Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Иргэний танхим гэх мэт) сахиж мөрдөхийг дэмжсэн. Орон нутгийн захиргааны үндсэн чиг үүргийн нэг нь төр засгийн хууль бодлогын хэрэгжилтийг хангах учраас төслийн дэмжлэг энэ тал дээр чухал ач холбогдолтой байсан байна. Өөрөөр хэлбэл, улсын хууль дээр төвлөрсөн нь орон нутгийн захиргааны хэрэгцээ шаардлагатай нийцсэн байна.
- Орон нутгийн хэрэгцээ шаардлага дэмжлэгийг хөтөлсөн – Саналаа илэрхийлсэн оролцогчдын дөрөвний нэг нь (24 оролцогчдын 6) төслийн дэмжлэг орон нутгийн захиргааны хэрэгцээ шаардлагад тулгуурлаж, санаачлагыг дэмжсэнийг онцолсон байна. Төслийн хүрээнд олгосон туслалцаа дэмжлэгийг орон нутгийн захиргааны онцлог шинжээс хамааралтай болгосон явдалд талархаж байна. Оролцогчдын дурдсан жишээнд ОНТИОН төслийн санхүүжилтээр вэбсайт, ФМ радио, телевиз, сонинтой болох зэрэг санаачлага хэрэгжүүлсэнийг хэлсэн байна.

Ярилцлаганд хамрагдсан оролцогчдоос ирээдүйд ямар асуудлыг шийдэхэд тусламж дэмжлэг авах хүсэлтэй байгааг асуусан байна. Оролцогчдын дийлэнх нь төслийн эхний шатны арга хэмжээг үргэлжлүүлэхийг дэмжсэн байна. Тэгсэн хэдий ч оролцогчид зарим сэдвээр санал дэвшүүлсэн байна:

- Олон нийтийн хурал уулзалтын иргэдийн ирц, оролцоог нэмэгдүүлэх
- Багийн түвшинд олон нийтийн хурал, уулзалт, харилцан яриа, хэлэлцүүлгийг дэмжих
- Төслийн үйл ажиллагааны чанар болон хэрэгжилтийг сайжруулах – өндөр үр чадвартай зохицуулагч нарыг ажиллуулах, төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавих

¹¹ Энэхүү дүрс дэх тоонууд нь дамтамжийг илэрхийлнэ

- Орон нутгийн захиргааны үйл ажиллагаанд иргэдийн зүгээс хяналт тавихыг дэмжих
- Алслагдмал айл өрхийн гишүүдэд олон нийтийн хурал уулзалтанд оролцох замын зардалд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, орон нутгийн захиргаа алслагдмал нутаг дэвсгэрт олон нийтийн хурал уулзалт хийх боломжийг дэмжих
- Орон нутгийн захиргааны ажилтан болон төрийн албан хаагчдын мэргэжлийн үр чадвар болон ойлголт мэдлэгийн түвшин нэмэгдүүлэхийг дэмжих. Төслийн үр дүнд иргэдийн ойлголт мэдлэг болон хэрэгцээ шаардлага нэмэгдсэн (өөрөөр хэлбэл иргэдийн оролцоо нэмэгдэж төрийн үйлчилгээний шаардлага өссөн) бөгөөд үүнд нийцүүлэн орон нутгийн захиргааны ажиллах хүчин мөн үр чадвараа дээшлүүлэх хэрэгцээ гарсан

2. Ашигт ажиллагаа

Судалгаанд хамрагдсан оролцогчдоос ОНТИОН төслийн үр дүнд орон нутгийн захиргааны албан хаагчид олон нийтийг мэдээллээр хангах, иргэдтэй зөвлөх үйл явцад өөрчлөлт гарсан эсэхийг асуусан байна. Энэ асуултын үр дүн маш эерэг гарсан бөгөөд оролцогчдын дийлэнх нь гарсан өөрчлөлтүүдийг нэрлэсэн байна. Асуултын үр дүнг Зураг 40 харуулж байна.

Зураг 41 Has FOCE’s support changed the way public consultation is conducted?



Оролцогчдын үзэж байгаагаар олон нийтийн хурал уулзалт, харилцан яриа, хэлэлцүүлгийн зохион байгуулалтанд дараах өөрчлөлтүүд гарсан байна:

- Бэлтгэл болон зохион байгуулалт – олон нийтийн хурал уулзалт, харилцан яриа, хэлэлцүүлгийн бэлтгэл ажил өөрчлөгдсөн. Жишээ нь, орон нутгийн захиргаа иргэдэд урьдчилан мэдээллэж урилга илгээдэг болсон бөгөөд хурлын хөтөлбөр болон хэлэлцэх асуудлын талаар мэдээллэдэг болсон (24 оролцогчдын 4)
- Дүрэм журам – сум болон хорооны түвшинд олон нийтийн хурал уулзалт, харилцан яриа, хэлэлцүүлэг зохион байгуулах албан ёсны дүрэм журам боловсруулсан (24 оролцогчдын 6)
- Техникийн болон бусад нөөц – Иргэдийн оролцоог дэмжих зориулалттай тавилга, микрофон, чанга яригч, цагаан самбар, цайны цаг зэрэг техникийн болон бусад нөөц сайжирсан (24 оролцогчдын 10)


- Хурлын зохицуулагч – Өндөр үр чадвартай хурлын зохицуулагч олон нийтийн хурал уулзалт, харилцан яриа, хэлэлцүүлгийн зохион байгуулалтыг сайжруулахын зэрэгцээ хөтөлбөрийн дагуу хэлэлцэх асуудал дээр төвлөрдөг болсон (24 оролцогчдын 7)

Оролцогчдын үзэж байгаагаар орон нутгийн захиргаа олон нийтэд мэдээлэл түгээх үйл явцад дараах өөрчлөлтүүд гарсан байна:

- Төслийн үр дүнд орон нутгийн захиргааны мэдээлэл түгээх давтамж нэмэгдэхээс гадна иргэдийг мэдээллээр хангах арга замын тоо болон чанар сайжирсан байна. Тэгсэн хэдий ч орон нутгийн захиргааны санхүүгийн хязгаарлалтаас хамаарч эдгээр шинэ санаачлагын цаашид хэрэгжүүлэх хүндрэлтэй байна (24 оролцогчдын 15)
- Иргэдийг мэдээллээр хангах шинэлэг сувгууд ашиглаж эхэлсэн (гар утасны мессеж, вэбсайт, орон нутгийн телевизийн суваг, улирал тутмын сонин болон сэтгүүл, шинэ мэдээллийн самбарууд, төслийн гарын авлага гэх мэт) (24 оролцогчдын 13)

Мөн оролцогчдын үзэж байгаагаар ОНТИОН төслийн сургалт семинар болон бусад техникийн туслалцааны үр дүнд олон нийтийн хурал уулзалт, харилцан яриа, хэлэлцүүлэг дэх иргэдийн оролцооны чанар дээшилсэн байна. Төрийн албан хаагчдын үзэж байгаагаар олон нийтийн хурал уулзалт, харилцан яриа, хэлэлцүүлэгт оролцож байгаа иргэд илүү зохион байгуулалттай болохын зэрэгцээ дүрэм журмын талаар ойлголт мэдлэгтэй болж хурлын хөтөлбөрийн дагуу хэлэлцэх асуудлын талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг болсон байна. Түүнээс гадна, иргэд орон нутгийн захиргаанд санал хүсэлт, гомдол, өргөдөл гаргах үйл явц сайжирсан. Иргэд ойлголт мэдлэгтэй болсон тул хэнд хэрхэн санал хүсэлтээ гаргахаа мэддэг болсон. Орон нутгийн захиргааны албан хаагчдаас ОНТИОН төслийн материалуудыг ашиглаж байгаа эсэхийг асуусан байна. Энэ асуултын үр дүнг Зураг 41 харуулж байна.

Зураг 42 Та өөрийн ажлыг гүйцэтгэхдээ төслийн боловсруулсан хэвлэмэл материал, тайлан эсвэл медиа материалыг ашигладаг уу?




Судалгаанд хамрагдсан бүх оролцогчид ОНТИОН төслийн тайлан материалыг ашиглаж байна.

3. Бүтээмж

Судалгаанд хамрагдсан оролцогчдоос төслийн хүрээнд орон нутгийн захиргааны төрөл бүрийн хэрэгцээ шаардлагад чиглэсэн туслалцаа дэмжлэгүүдийг бүтээмж, хувь нэмэр, ач холбогдолоор нь жагсаахыг асуусан байна. Энэ асуултын үр дүнг Зураг 42 харуулж байна.

Зураг 43 Орон нутгийн төрийн байгууллага дахь Төслийн шууд дэмжлэгийн алийг нь та хамгийн чухал гэж үнэлэх вэ?



N= 38

Оролцогчдын үзэж байгаагаар хамгийн чухал дэмжлэгийн хэлбэр нь бага хэмжээний мөнгөн тусламжийн сан байсан бөгөөд оролцогчдын гуравны хоёр нь сонгосон байна. Хоёрт хөндлөн суралцах арга хэмжээний оролцоо, дараа нь орон нутгийн зохицуулагч орсон байна.

Нийт 38 оролцогчдын 14 нь энэ гурван дэмжлэгийн хэлбэр бүгд ижил хэмжээний ач холбогдолтой байсан гэж хариулсан байна. Оролцогчид мөн чанарын шинжтэй саналууд өгсөн бөгөөд зарим жишээг түүвэрлэн оруулав:

Бага хэмжээний мөнгөн тусламжийн сангийн талаар:

Оролцогчдын үзэж байгаагаар орон нутгийн албан хаагч болон иргэдийн санаачлага болон арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн туслалцаа дэмжлэг шаардагддаг бөгөөд бага хэмжээний мөнгөн тусламжийн сан энэ хэрэгцээ шаардлагыг хамгийн үр ашигтайгаар хангасан байна.

“Бага хэмжээний мөнгөн тусламжийн сан нь төслийн хамгийн чухал шууд дэмжлэг байв. Хангалттай санхүүгийн нөөц хуваарилаагүй тохиолдолд ямар ч асуудлыг шийдэх боломжгүй. Энэхүү мөнгөн тусламжийн санг байгуулсанаар маш олон асуудлыг шийдэж чадсан.”

–Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Дарга

Хөндлөн суралцах семинарын талаар:

Улсын хэмжээний сургалт семинарууд орон нутгийн захиргаанд өөрийн нийгмийн бүлгийн ололт амжилтыг үнэлхээс гадна бусад орон нутгийн сайн туршлага, үлгэр жишээ дадлагатай харьцуулах боломж олгосон.

“Энэхүү улсын хэмжээний сургалт семинарууд нь төслийн хамгийн чухал дэмжлэгийн хэлбэр байсан. Энэ бол маш чухал. Сургалт семинарууд нь бидэнд өөрсдийн ажлыг үнэлэх, бусад орон нутагтай харьцуулах боломж олгож байна. Мөн түүнээс гадна, бидний үйл ажиллагааны сул болон давуу талуудыг тодорхойлоход тусалж, зөв арга замыг сурах, бусад хүмүүст бидний ажлыг үнэлэх боломж олгож байна.”

– Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Дарга

Орон нутгийн зохицуулагчийн талаар:

Оролцогчдын үзэж байгаагаар орон нутгийн зохицуулагч нар олон нийтийн хурал уулзалт зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, орон нутгийн захиргааны мэдээллийг түгээх, шинэчлэхэд их хувь оруулсан байна.

4. Тогтвортой хөгжил

Нийт оролцогчдын гуравны хоёр нь төсөл дууссаны дараагаар гадны туслалцаа дэмжлэг авахгүй бол шинээр санаачилсан үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийг өөрчлөх эсвэл таслан зогсоохоос өөр аргагүй гэсэн байна. Нийт оролцогчдын дөрөвний нэг нь л гадны туслалцаа дэмжлэггүй шинэ санаачлага болон арга хэмжээнүүдийг үргэлжүүлэн хэрэгжүүлэх болно гэж хариулсан байна. Эдгээр оролцогчид Хан-Уул дүүрэг, Төв, Архангай, Дэлгэрцогт болон Дундговь аймгаас байв.

Судалгаанд оролцогчид тогтвортой хөгжил болон төслийн 2-р шатны талаар дараах саналуудыг дэвшүүлсэн байна:

- Аймагт ганц биш харин төслийн талбар болгонд өөрийн зохицуулагчтай болох
- Төслийн мэргэжилтнүүд улс төрийн сонирхолгүй байхаас гадна мэргэжлийн өндөр үр чадвартай байх
- Бүх талбарт ижил хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- Ирээдүйд анхаарал хандуулах асуудлуудад орон нутгийн захиргааны ажилчдын ойлголт мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх, алслагдмал нутаг дэвсгэрт оршин суудаг иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг дурьдав

БҮЛЭГ VI. ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүн ОНТИОН төсөл нь зорилтот бүлгийн иргэдийн орон нутгийн засаглалын талаарх дэлгэрэнгүй ойлголт мэдлэгийн түвшнийг нэмэгдүүлсэнийг харуулж байна. ОНТИОН зорилтот талбар дахь иргэдийн орон нутгийн захиргааны чиг үүргийн талаарх ойлголт мэдлэгийн агуулга болон чанар (гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалын талаар) суурь судалгаа болон хяналтын талбарын үзүүлэлтүүдтэй харьцуулахад сайжирсан байна. Зорилтот бүлгийн Төсвийн тухайн хуулийн талаар ойлголт мэдлэгийн агуулга болон чанар хяналтын бүлгийн үзүүлэлтээс илүү байхын зэрэгцээ зорилтот талбар дахь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн мэдлэг эрс сайжирсан байна (гэвч эцсийн мэдлэгийн түвшин хяналтын талбар дахь үзүүлэлттэй адил байна). Иргэдийн ойлголт мэдлэгийн түвшин дээшилсэн нь төслийн хамгийн том амжилт юм. Үүнтэй холбоотойгоор ОНТИОН төсөл нь хяналтын талбартай харьцуулахад зорилтот талбар дахь мэдээллийн эх сурвалжийн өргөжилтөнд хувь нэмэр оруулсан байна. Тэгсэн хэдий ч орон нутгийн захиргааны үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээллийн ил тод байдлын талаар иргэдийн үзэл зорилтот болон хяналтын талбарт ижил хэмжээгээр сайжирсан энэ өөрчлөлт ОНТИОН төслийн хөндлөнгийн оролцоонд шууд хамааралгүйг илтгэж байна.

Орон нутгийн шийдвэр гаргах хурал уулзалтын хувьд зорилтот талбар дахь иргэд шийдвэр гаргах явцад оролцох боломжуудын талаар хяналтын талбар дахь иргэдээс илүү мэдлэгтэй болсон бөгөөд оролцооны үзүүлэлт нь суурь судалгааны үзүүлэлтээс 14 хувиар өссөн байна. Тэгсэн хэдий ч хяналтын талбар дахь хурал уулзалтын ирц адил хэмжээгээр өссөн тул ирцийн түвшин нэмэгдсэн өөрчлөлтийг зөвхөн ОНТИОН төслийн үр дүн гэж ойлгож болохгүй. Төслийн тухай хууль болон Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хэлэлцүүлгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд хурал уулзалтын ирц нэмэгдсэн байх өндөр магадлалтай. Зорилтот болон хяналтын бүлгийн иргэд хурал уулзалтын талаар орон нутгийн албан хаагчаас мэдэх тохиолдол суурь судалгааны үзүүлэлтээс өссөн нь дээрх таамаглалыг дэмжиж байна.

Хяналтын бүлэгтэй харьцуулахад хурал уулзалтыг сонирхоогүй учраас хуралд оролцоогүй иргэдийн тоо зорилтот бүлгийн хувьд цөөн байна. Зорилтот буюу түршилтын талбар дахь иргэд мөн хурал уулзалтын талаар илүү мэдээлэлтэй бөгөөд хяналтын бүлэгтэй харьцуулахад хурал уулзалт хэзээ болохыг мэдээгүйгээс болж хуралд оролцоогүй иргэдийн тоо цөөн байна.

